

# МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот,  
2018 оны 8 дугаар сар



# МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5483-MN Ухаалаг засаг төсөл

Улаанбаатар хот,  
2018 оны 8 дугаар сар

## ГАРЧИГ

ХУРААНГУЙ.....	2
АРГАЧЛАЛ.....	5
ТАЛАРХАЛ.....	6
1 УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ .....	9
2 БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	15
3 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ТӨРИЙН ХАРИУЦЛАГА, ЧАДАМЖ.....	22
4 ТӨРИЙН ӨГӨГДЛИЙН МЕНЕЖМЕНТ, ӨГӨГДЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ .....	29
5 НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЭРЭЛТ.....	37
6 ИРГЭДИЙН ОРОЛЦОО, НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН БОЛОМЖ.....	43
7 НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ .....	49
8 ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ДЭД БҮТЭЦ, УР ЧАДВАР .....	53
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	59
ХАВСРАЛТ .....	64

## ХУРААНГУЙ

Монгол Улс төрийн албаны үйл ажиллагааг цахимжуулж олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай, үр өгөөжтэй болгох, төрийн өгөгдөл, мэдээллийн ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014), Засгийн газрын 159 дүгээр тогтоол (2017) болон Засгийн газрын үйл ажиллагааны 2020 хүртэлх төлөвлөгөөнд тусгасан нээлттэй өгөгдлийн бодлого боловсруулах, нээлттэй өгөгдөлд суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, өгөгдлийн менежментийг сайжруулахаар ажиллаж байгаа нь Монгол Улсад Нээлттэй өгөгдлийг бодитоор хөгжүүлэх боломж нөхцөл бүрдүүлж байна.

Нээлттэй өгөгдлийн санаачилгыг эхлүүлж байгаа Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ), Үндэсний дата төв (ҮДТ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (ТӨБЗГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) зэрэг төрийн байгууллагууд хууль эрх зүй, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төрийн өгөгдлийг машин унших форматаар нээлттэй нийтэлсэн байна. Дараах хүснэгтэд нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд оролцогч гол байгууллагууд, тэдний үүрэг, үзүүлж буй нөлөө, хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүрсэн ололт амжилтаас тоймлон үзүүлэв.

ГОЛ БАЙГУУЛЛАГУУД	ҮҮРЭГ, НӨЛӨӨ	ХӨГЖҮҮЛЭЛТ, ОЛОЛТ
ХХМТГ	“Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн нээлттэй өгөгдлийн бодлого, Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл, Цахим засаг үндэсний хөтөлбөр зэргийг боловсруулж байна.</li> </ul>
ҮДТ	Төрийн мэдээлэл солилцооны дэд бүтцийг хөгжүүлж байгаа.	<ul style="list-style-type: none"> <li>“ХУР”, “ХУРДАН” зэрэг системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн.</li> </ul>
ҮСХ	Төрийн нээлттэй өгөгдлийн санаачилгыг түүчээлэн, үлгэрлэж байна. Төрийн байгууллагын	<ul style="list-style-type: none"> <li>1212.mn порталд статистикийн 700+ өгөгдлийн бүрдлийг СС-ВУ лицензтэй, машин унших форматаар</li> </ul>

	<p>өгөгдлийг боловсруулж нийтлэх чадавхыг харуулж буй сайн жишээ болж байна.</p>	<p>нийтэлсэн. 2017 оны ODIN тайланд дэлхийд 24, зүүн Азид 2 дугаар байрт орсон байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Машин хооронд өгөгдөл солилцох API (<a href="http://opendata.1212.mn">opendata.1212.mn</a>) хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн.</li> </ul>
ТӨБЭГ	<p>Нээлттэй засгийн түншлэл, нээлттэй өгөгдлийн уялдааг харуулсан сайн жишээ болж байна.</p> <p>Төрийн нээлттэй өгөгдлийн санаачилгыг түүчээлэн, үлгэрлэж байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>Нээлттэй гэрээний олон улсын стандартын дагуу машин унших форматаар тендерийн өгөгдлийг <a href="http://opendata.tender.gov.mn">http://opendata.tender.gov.mn</a> порталд нийтлээд байна.</li> </ul>
УБЕГ	<p>Улсын бүртгэлийн багц хуульд (2018) төрөл бүрийн зорилгоор ашиглах суурь жишиг өгөгдлийг нээлттэй, ил тод байлгах аар боловсруулж батлуулсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>Хуулийн этгээд, хаяг, эд хөрөнгө зэрэг улсын бүртгэлийн мэдээллийг <a href="http://opendata.burtgel.gov.mn">http://opendata.burtgel.gov.mn</a> порталд нийтэлсэн.</li> </ul>
Ухаалаг Засаг төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгж	<p>Төрийн нээлттэй өгөгдлийн порталыг хөгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулахаар ажиллаж байгаа.</p>	<ul style="list-style-type: none"> <li>Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг Ухаалаг засаг төслөөс гарааны шатанд санхүүжүүлж, нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд зөвлөх, техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлж байгаа.</li> </ul>

Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд улс төр, удирдлагын манлайлал, өгөгдөл, мэдээллийн талаарх бодлого, эрх зүйн орчин, байгууллагын бүтэц, төрийн хариуцлага, чадамж, төрийн өгөгдлийн менежмент, төрийн өгөгдлийн эрэлт, нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилт, технологийн үндэсний дэд бүтцийн бэлэн байдал, өнөөгийн нөхцөлийг үнэлж, түүнд түшиглэн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээг (НӨББҮ) хийж гүйцэтгэсэн.

Энэ үнэлгээний ажлын цар хүрээг нийгэмд бодитой нөлөө үзүүлэх, өндөр хэрэглээтэй гол өгөгдлийн бүрдлийг нийтлэхэд бэлэн байгаа эсэх, цааш нь хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг олж тодорхойлох зорилгоор гол өгөгдлийн бүрдэл талаас; төрийн байгууллагын бүтцийн бүх түвшинд өгөгдөл, мэдээллийн асуудал хариуцдаг байгууллага, гол өгөгдлийн бүрдэл агуулагч

байгууллага, бусад өгөгдлийн бүрдэл эзэмшигч байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон өгөгдөл хэрэглэгч зэрэг үнэлгээний зорилгод нийцэх байгууллагын талаас тодорхойлсон болно.

Энэ НӨББУ-ий үр дүн нээлттэй өгөгдлийг Монгол улсад хөгжүүлэхэд улс төрийн манлайлал маш их дутагдаж байгааг харуулж байна. Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд саад болох хууль, дүрэм байхгүй харин дэмжлэг болох хууль, засгийн газрын тогтоол байна. Төрийн бус байгууллага, академик байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээллийн салбарт төрийн өгөгдлийн эрэлт их байгаа боловч төрийн зүгээс өгөгдөл дээр тулгуурласан төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох, төрийн өгөгдлийн эрэлтийг тодорхойлох ажил хийгдэхгүй байна. Монгол улс сүүлийн жилүүдэд мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц болон төрийн мэдээллийн системүүдэд харьцангуй сайн хөрөнгө оруулалт хийж байгаа ч төрийн байгууллагын өгөгдлийн удирдлага, төрийн албан хаагчдын харилцаа холбооны технологийн чадавх сул, албан хаагчдын ажлын үнэлгээнд мэдээлэл технологийн чадавхыг үнэлэхгүй байгааг харж болно.

Үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсад нээлттэй өгөгдлийн санаачилгыг цаашид тогтвортой хөгжүүлэх, нээлттэй өгөгдлийн экосистемийг бүрдүүлэхэд дараах зүйлсийг сайжруулах, хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Үүнд:

1. Нээлттэй өгөгдөл, түүний бий болгох боломж, ач холбогдлыг засгийн газрын бүх түвшинд болон иргэд олон нийтэд таниулан сурталчлах, улс төрийн манлайллыг удирдлагын дээд түвшинд бий болгох;
2. Төрийн өгөгдлийг дахин ашиглах, лицензжүүлэх, хувийн нууцыг хамгаалах, эзэмшлийг тодорхой болгох;
3. Төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өгөгдлийн түвшинд илүү ойртуулж хөгжүүлэх;
4. Нээлттэй өгөгдлийн хэрэглээг дэмжсэн инновацийн сан байгуулах, төр хувийн хэвшлийн хамтын бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулах;
5. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг удирдан хэрэгжүүлэх олон талт оролцоог хангасан ажлын хэсгийг байгуулж ажиллах;

Энэхүү үнэлгээний үр дүнд нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын нэгдсэн үнэлгээ, гол өгөгдлийн бүрдлийн тойм тодорхойлолт, нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж гаргасан.

## АРГАЧЛАЛ

Энэхүү “Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээг” (НӨББҮ) Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (ЗГХЭГ) захиалгаар Ухаалаг засаг төслийн дэмжлэгтэй мэргэжлийн хамтарсан баг хийж гүйцэтгэсэн болно.

Үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засгийн газраас Нээлттэй өгөгдлийн санаачилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох, төлөвлөхөд туслах юм. Энэ санаачилгаар Нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталыг үүсгэх, өгөгдлийг нийлэх, дахин ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, нээлттэй өгөгдлийн хөтөлбөр болон нээлттэй өгөгдөлд түшиглэсэн инновацийг санхүүжүүлэх, өгөгдлийг нийтлэх, ашиглах ур чадварын хөгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэдэг.

Үнэлгээг Дэлхийн банкнаас боловсруулсан НӨББҮ аргачлалаар хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ нь Нээлттэй өгөгдлийн “экосистем” аргыг ашигладаг. Экосистем нь Нээлттэй өгөгдлийн “нийлүүлэгч” талын бодлого, хууль эрх зүйн зохицуулалт, төрийн өгөгдлийн бэлэн байдал, хатуу болон зөөлөн дэд бүтэц (менежмент, стандарт г.м) болон “эрэлт” талын иргэдийн оролцооны механизм, өгөгдлийн хэрэглэгчдийн (програм хөгжүүлэгчид, хэвлэл мэдээллийнхэн болон төрийн бусад агентлаг, байгууллагууд) бодит эрэлт зэрэг асуудлыг хамтатгаж илүү өргөн хүрээнд авч үздэг. Дээрх асуудлыг найман хэмжүүр үзүүлэлтэд хувааж бэлэн байдлын үнэлгээг хийсэн болно.

Бэлэн байдлын үнэлгээ нь Нээлттэй өгөгдлийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, авч хэрэгжүүлэх арга хэмжээг найман хэмжүүр тус бүрийн хувьд санал болгоход чиглэсэн болно. Үнэлгээний үр дүнд гарсан зөвлөмж болон төлөвлөсөн үйл ажиллагаа, арга хэмжээг олон улсын шилдэг туршлага, Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсрууллаа. Үнэлгээний хэмжүүр бүрд хамаарах гол асуултуудын хувьд нээлттэй өгөгдлийн бэлэн байдлыг дэмжиж байгаа эсэх талаар цуглуулсан



баримт, нотолгоонд тулгуурлан НОГООН, ШАР, УЛААН өнгөөр үнэлсэн болно. Гол асуулт тус бүрийн үнэлгээнд түшиглэж тухайн хэмжүүрийн нэгдсэн үнэлгээг мөн өнгөөр үнэлсэн.

Үүнд,

- НОГООН - Бэлэн байдал нотлогдсон үед
- ШАР - Бэлэн байдал нотлогдоогүй үед,
- УЛААН - Бэлэн бус байдал нотлогдсон үед

Гол асуултад хариулах явцад бэлэн байдлын нотолгоо тодорхой бол <<+>> (нэмэх) тэмдэг, бэлэн байдлын нотолгоо тодорхойгүй үед <<->> (хасах) тэмдэг, бэлэн байдлын нотолгоо нь хоёрдмол утгатай, тодорхойгүй эсвэл үнэлгээний жин багатай үед <<0>> тэмдгээр тэмдэглэсэн. Гол асуултын ерөнхий өнгийг тогтооход холбогдох нотолгоо бүрд ижил жин өгч үнэлээгүй. Бэлэн байдлыг тодорхойлох үед зарим хүчин зүйлүүд илүү их жинтэй байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://opendatatoolkit.worldbank.org/en/odra.html> сайтаас танилцах боломжтой.

## ТАЛАРХАЛ

Энэхүү бэлэн байдлын үнэлгээний тайланг бэлтгэж боловсруулахад бүх талаар тусалж дэмжсэн Монгол Улсын Засгийн газар, ЗГХЭГ, Дэлхийн банк, Ухаалаг засаг төслийн нэгжийн хамт олонд талархал дэвшүүлж байна. Мөн үнэлгээг хийж гүйцэтгэхэд хамтран ажиллаж шаардлагатай мэдээллээр хангаж тусалсан төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагад (Хавсралт Б) талархал дэвшүүлье.

Мөн тайланд санал зөвлөмж ирүүлсэн болон хянан тохиолдуулсан ХХМТГ, Үндэсний дата төв (ҮДТ), ҮСХ зэрэг байгууллагад талархаж байна.

## МЭДЭГДЭЛ

Энэхүү НӨББҮ-ий тайланд тусгасан аливаа урьдчилсан дүгнэлт, зөвлөмж нь үнэлгээний явцад хийсэн ярилцлага, Засгийн газар болон дотоодын бусад оролцогч талуудаас ирүүлсэн баримт бичиг болон тэдгээрийн үзэл баримтлалд тулгуурласан болно. Энэ тайлан нь хууль, эрх зүйн нарийн шинжилгээнд үндэслээгүй, хууль зүйн ямар нэг зөвлөмж өгөөгүй болно. Иймд, нээлттэй өгөгдлийн бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд хэрэгжүүлж болох аливаа үйл ажиллагаа, зөвлөмж, үнэлгээний тохиромжтой, оновчтой эсвэл хангалттай үндэслэл болохгүй.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
МХТ	Мэдээлэл холбооны технологи
АЕГ	Архивын ерөнхий газар
МТҮП	Мэдээллийн технологийн үндэсний парк
СЯ	Сангийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ТатЕГ	Татварын ерөнхий газар
ҮДТ	Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
МУИС	Монгол Улсын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
НӨАТУС	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем
ОУЦХБ	Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
НӨББҮ	Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
API	Application Programming Interface
CIO	Chief of Information Officer
CTO	Chief of Technology Officer
JSON	JavaScript Object Notation
CSV	Comma-Separated Values
HTML	HyperText Markup Language

## 1 УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ

**Ач холбогдол:** Маш өндөр

**Агуулга:** Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихэвчлэн хууль эрх зүй, байгууллагын тогтолцоо, технологийн болон соёлын өөрчлөлт, шинэчлэл шаардлагатай байдаг. Улмаар энэхүү өөрчлөлт, шинэчлэл нь бодлого тодорхойлогч, оролцогчид болох төр болон бусад талуудад тодорхой нөлөөллийг бий болгодог. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцад анхаарал хандуулж, хүчтэй, тогтвортой, улс төрийн/удирдлагын манлайллыг бий болгох нь төрөөс шинэчлэлийг хэрэгжүүлэхэд учирч болох аливаа саад бэрхшээл, эсэргүүцлийг даван туулахад дэмжлэг болох төдийгүй аливаа шинэчлэл өөрчлөлтийг цаг тухайд нь үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх, Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн зорилго ач холбогдлыг бүрэн хангахад нэн чухал хүчин зүйл болно.

### 1.1 Нээлттэй өгөгдлийн/Нээлттэй Засгийн/Мэдээлэл авах эрхийн талаар улс төрийн манлайлал хэр байдаг вэ? (Ач холбогдол: Маш өндөр)

- + Ерөнхийлөгч/Ерөнхий сайдын зүгээс нээлттэй өгөгдлийг дэмжсэн байр суурийг одоогоор нийтэд илэрхийлээгүй байгаа боловч Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийг санг бүрдүүлэх ашиглах журам”<sup>1</sup>-ын 5.4.8 дугаар зүйлд “Нээлттэй өгөгдлийг мэдээллийн системд уншигдах хэлбэрээр иргэн, байгууллага ашиглах боломжийг бүрдүүлэх” гэж заасан байгаа нь ерөнхий сайд болон засгийн газрын түвшинд нээлттэй өгөгдлийг дэмжиж байгаа гэж үзэж байна.
- o Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (ЗГХЭГ) дарга засаглал, чиг үүргийнхээ хувьд нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг манлайлж ажиллах боломжтой. Тэрээр мэдээллийн технологийн бодлогын зөвлөлийг 2017 оны 12 сард байгуулж удирдан ажиллаж байгаа бөгөөд ил тод, нээлттэй байх зарчмыг баримталж байгаа.

---

<sup>1</sup> Засгийн газрын 2017-ны 159 дүгээр тогтоол, *Төрийн мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглах журам*, <http://www.legalinfo.mn/annex/details/7897?lawid=12739>, хандсан: 2018-05-24

- + ТӨБЗГ төрийн худалдан авах үйл ажиллагааны нээлттэй өгөгдлийн порталыг<sup>2</sup> Нээлттэй гэрээний олон улсын стандартаар<sup>3</sup> хөгжүүлж бэлэн болгосон.
- + "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай"<sup>4</sup> хуулийн 3.1-д заасан төрийн болон төрийн оролцоотой бүх байгууллагын төсвийн захирагч, ерөнхий менежер нар мэдээлэл авах эрхийн асуудлыг хариуцдаг. Хуульд ямар нэг чиг үүргийн сайд хариуцахаар тусгайлан заагаагүй. Гэхдээ ЗГХЭГ, Авлигатай тэмцэх газар (АТГ) ил тод байдлын үнэлгээг төрийн байгууллагуудад хийдэг. Нээлттэй засаглалыг Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга удирдан ажилладаг.
- ЗГХЭГ-ын дарга "Хөгжлийг дэмжих өгөгдөл", мөн газрын дэд дарга "Төрийн нээлттэй өгөгдөл хэлэлцүүлгийг" төрийн захиргааны байгууллагуудын дунд 2016 онд зохион байгуулж байсан. Улс төрийн түвшинд нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх асуудлыг дэвшүүлж, манлайлан тогтвортой ажиллаж байгаа улс төрч байхгүй.

## **1.2 Засгийн газрын хэмжээнд бүхэлд нь эсвэл төрийн байгууллага хоорондын хөтөлбөрийн хэрэгжилт, бодлогод тогтсон улс төрийн манлайлал, засаглалын загвар байна уу? (Ач холбогдол: Өндөр)**

- + Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын барим бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэх журам"-д заасны дагуу үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрийг ЗГХЭГ-т тайлагнадаг бөгөөд үүнийг удирдан ажилладаг засаглалын тогтсон загвар байдаг.
- + Улсын Их Хурлаар (УИХ) баталсан үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөрт Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд,

<sup>2</sup> Open Contracting Mongolia, <http://opendata.tender.gov.mn>, хандсан: 2018-06-05

<sup>3</sup> Open Contracting Data Standard, <https://www.open-contracting.org/data-standard/>, хандсан: 2018-04-6

<sup>4</sup> Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/374>, хандсан: 2018-06-05

бүтцийн бие даасан агентлагууд бүгд хамрагддаг.

### 1.3 Нээлттэй өгөгдөлтэй холбоотой улс төрийн ямар үйл ажиллагаа, төлөвлөгөө байна вэ? (Ач холбогдол: Дунд)

- + 2016 онд "Хөгжлийг дэмжих өгөгдөл"<sup>5</sup> чуулганыг төр, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагуудын дунд зохион байгуулсан байдаг. Энэ арга хэмжээг ЗГХЭГ-ын дарга удирдан зохион байгуулсан. Мөн тус газрын дэд даргын санаачилгаар "Төрийн нээлттэй өгөгдөл"<sup>6</sup> хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ, яам, агентлаг, судалгаа шинжилгээний байгууллага, хувийн хэвшил болон иргэний нийгмийн 60 гаруй байгууллагын 120 гаруй төлөөлөгчийн дунд 2016 оны 11 сард зохион байгуулсан.
- Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх ямар нэг үйл ажиллагааны төлөвлөгөө одоогоор байхгүй байна.
- Нээлттэй өгөгдлийг нийгэмд хэвшил болгох, ойлголтыг дээшлүүлэх талаар ямар нэгэн үйл ажиллагааг олон нийтийн дунд зохион байгуулаагүй байна.
- + Монгол улс Нээлттэй засгийн түншлэлд<sup>7</sup> 2013 оноос нэгдэн орсон ба Үйл ажиллагааны төлөвлөгөө I (2014-2016), II (2016-2018) боловсруулж ажилласан. Үйл ажиллагааны I төлөвлөгөөний дагуу байгаль орчны ил тод байдал, төсвийн мэдээллийг ил тод байдал, гэмт хэргийн газрын зураг зэрэг ажлууд улс төрчдийн дэмжлэг авч үр дүнтэй, амжилттай хэрэгжсэн.
- Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны I төлөвлөгөөнд тусгасан 21 зорилтоос 14 нь бүрэн хэрэгжээгүй байна.
- + Нийслэлийн мэдээллийн технологийн газар Нийслэлийн их ба нээлттэй өгөгдлийн төслийг<sup>8</sup> 2015 онд хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд 60+ өгөгдлийн

<sup>5</sup> "Хөгжлийг дэмжих өгөгдөл" чуулган Төрийн ордонд боллоо, <http://zasag.mn/news/view/12264>, хандсан: 2018-04-10

<sup>6</sup> "Төрийн нээлттэй өгөгдөл" хэлэлцүүлэг, <https://www.news.mn/?id=251143>, хандсан: 2018-04-14

<sup>7</sup> Нээлттэй засгийн түншлэл - Монгол улс, <https://www.opengovpartnership.org/countries/mongolia>, хандсан: 2018-06-05

<sup>8</sup> Нийслэлийн нээлттэй өгөгдлийн портал, <http://data.ulaanbaatar.mn>, хандсан: 2018-05-06

бүрдэл нийтэлсэн. Мөн “Нийслэлийн их ба нээлттэй өгөгдөл зохицуулах журам”<sup>9</sup> батлагдсан.

- + ҮСХ нээлттэй өгөгдлийг<sup>10</sup> хөгжүүлж 700+ өгөгдлийн бүрдэл нийтлээд байна.

#### **1.4 Улс төрийн өргөн хүрээнд нээлттэй өгөгдлийг хэрхэн дэмждэг эсвэл саад байгаа юу? (Ач холбогдол: Өндөр)**

- + Засгийн газрын үйл ажиллагааны 2020 хүртэлх төлөвлөгөөнд<sup>11</sup> нээлттэй өгөгдлийн бодлого боловсруулах, нээлттэй өгөгдөлд суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх зорилтот үйл ажиллагаа тусгагдсан байдаг ба нээлттэй өгөгдлийн тэргүүлэх чиглэлээс ил тод байдал, төрийн үйлчилгээг сайжруулж үр ашигтай болгох чиглэлийг чухалчилж байгаа.
- + УИХ-ийн чуулганаар 2018 оны 05 сард Цахим бодлогын түр хороог<sup>12</sup> байгуулсан. Энэ хороог санаачлагч УИХ-ийн гишүүн бөгөөд Монгол улсын сайд, ЗГХЭГ-ийн дарга Г.Занданшатар, УИХ-ийн гишүүн Ж.Энхбаяр, Н.Учрал нар нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.
- + Улс төрийн сонгууль 4 жилийн мөчлөгтэй явагддаг бөгөөд дараагийн сонгууль болоход 2 жил үлдсэн байгаа. Энэ хугацаанд нээлттэй өгөгдлийн үндэсний хөтөлбөрийг баталж өгөгдлийг нийтлэх үйл ажиллагааг эрчимжүүлж тогтворжуулах бүрэн боломжтой.
- o Нээлттэй өгөгдөлтэй холбоотойгоор нийгэмд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах, төрийн үйлчилгээг цахимжуулж ил тод, шуурхай болгох улс төрийн сонирхол бий. Нөгөө талаас өгөгдлийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, нээлттэй болсноос үүдэн гарах асуудалд болгоомжилдог.
- + Улс төрийн тэргүүлэх чиглэлд эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн ажил,

<sup>9</sup> Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-03-03-ны өдрийн А/170 тоот “Нийслэлийн их ба нээлттэй өгөгдлийг зохицуулах журам батлах тухай” захирамж

<sup>10</sup> Статистикийн нээлттэй өгөгдөл, <http://opendata.1212.mn>, хандсан: 2018-04-20

<sup>11</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016-10-26-ны өдрийн 121 дүгээр тогтоол, <http://legalinfo.mn/law/details/12308>, хандсан: 2018-03-18

<sup>12</sup> УИХ-ийн 2018-05-24-ний өдрийн 38 дугаар тогтоол, <http://www.legalinfo.mn/law/details/13411>, хандсан: 2018-06-04

үйлчилгээг ил тод, хүртээмжтэй, түргэн шуурхай, хүнд сурталгүй болгоход нээлттэй өгөгдлийн дэмжлэг авах боломжтой.

### **1.5 Нээлттэй засгийн түншлэлтэй холбоотойгоор тус улсын байр суурь ямар байна вэ?**

- Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлийн гишүүн бөгөөд ил тод, нээлттэй байдал, хариуцлага, иргэдийн оролцоо, технологи, инноваци зэрэг нээлттэй засгийн түншлэлийн зарчмуудад хамаарах 13 амлалт өгч Монгол Улсын нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны II төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа. Энэ төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийг бүрэн утга, агуулгаар эсвэл шууд утгаар нь хөгжүүлэхэд чиглэсэн амлалт тусгагдаагүй байна.
- Нээлттэй засгийн түншлэлд ямар нэг ажлын хэсгийн гишүүнээр ажиллах, тулгамдаж буй асуудлыг түүчээлэн шийдвэрлэхэд Монгол Улс манлайлж оролцдоггүй.
- + Нээлттэй засаглалын үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад Глоб интернэйшнл, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, Нээлттэй нийгэм хүрээлэн зэрэг Төрийн бус байгууллагууд (ТББ) оролцож, тайланд хөндлөнгийн шинжээчээр ажилласан туршлага бий.



Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Улс төрийн манлайлал	Маш өндөр	ШАР	Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд нээлттэй өгөгдлийг дэмжсэн байр суурийг олон нийтэд илэрхийлээгүй боловч ерөнхий сайд үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
Засаглалын загвар	Өндөр	НОГООН	Нээлттэй өгөгдлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд засаглалын тогтвортой загвар байна.
Хэрэгжиж буй үйл ажиллагаа	Дунд	НОГООН	Нээлттэй өгөгдлийг нийтэлдэг төрийн байгууллагууд байна.
Улс төрийн хүрээ	Өндөр	ШАР	ЗГ-ын 2020 хүртэлх төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийн бодлого боловсруулах, нээлттэй өгөгдөлд суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх тухай заасан төдий байна. Улс төрийн хүрээнд нээлттэй өгөгдлийг дэмжих байр суурийг илэрхийлсэн зүйлгүй.
Нээлттэй засгийн түншлэл		ШАР	Нээлттэй засгийн түншлэлд Монгол Улс гишүүн боловч манлайлж оролцдоггүй, дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт дунд, нээлттэй өгөгдлийн уялдаа тааруу.
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		ШАР	Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд гол хүчин зүйл болох улс төрийн/удирдлагын бодитой манлайллыг бий болгох хэрэгтэй.

## 2 БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

**Ач холбогдол:** Өндөр

**Агуулга:** Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд бодлого, хууль эрх зүйн зохицуулалт маш чухал юм. Тухайлбал, өгөгдлийг дахин ашиглах болон лицензжүүлэх, хувийн нууцыг хангах болон өгөгдөл хамгаалах, хувийн мэдээллийг тодорхойлж болохуйц өгөгдлийг нэргүй болгох гэх мэт зохицуулалт хэрэгтэй байдаг. Юуны өмнө бодлого, хууль тогтоомж, дүрэм журамд байгаа асуудал, бодлогод өөрчлөлт хийхэд тулгарч байгаа болон тулгарч болох бэрхшээл зэргийг олж тогтоох нь чухал байдаг. Хууль эрх зүйн байдлын үнэлгээг дээрх асуудлаар мэргэшсэн дотоодын болон олон улсын хуулийн зөвлөхийн тусламжтайгаар хийж гүйцэтгэх нь зүйтэй байдаг.

### 2.1 Хувийн нууцыг хамгаалах хууль эрх зүйн болон бодлогын орчин ямар байдаг вэ? (Ач холбогдол: Өндөр)

- + Хувь хүний нууцын тухай хууль<sup>13</sup> болон Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>14</sup> 16.17-р заалтаар хувь хүний нууцыг хамгаалах хуулийн ерөнхий зохицуулалттай.
- Хувь хүний өгөгдөл, мэдээллийг тодорхой зорилгоор ашиглах, хамгаалах талаар нарийн зохицуулсан хууль тогтоомж байхгүй байна.
- + Хувийн нууцад хамаарах өгөгдөл хадгалагч аливаа төрийн байгууллага хуулийн хүрээнд өөрийн дотоод журмын дагуу хамгаалалтыг хариуцах үүрэгтэй. Байгууллага бүрд зөвхөн хувь хүний нууцад хандах эрхтэй ажилтан хувь хүний нууцын мэдээлэлд хандах эрхтэй.
- Өгөгдөл хамгаалах хуулийн төслийг ХХМТГ боловсруулж байгаа. Өгөгдлийг автоматаар боловсруулах, дамжуулах, түгээх харилцаанд хувийн нууцыг хамгаалдаг тогтолцоо, механизм байхгүй байна.
- o Хувь хүний нууцыг хамгаалах хуулийн хэрэгжилт сул, хувийн нууцыг

<sup>13</sup> Хувь хүний нууцын тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/537>, хандсан: 2018-03-5

<sup>14</sup> Монгол Улсын Үндсэн хууль, <http://www.legalinfo.mn/law/details/367>, хандсан: 2018-03-10

хамгаалах механизм, хамгаалалт үр дүнгүй эсвэл үр дүнтэй гэх хангалттай мэдээлэл байхгүй. Шүүхээр хувь хүний нууцтай холбоотой шийдвэрлэгдсэн хэргийн тохиолдол маш цөөн байна.

- Хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нэгдсэн бүртгэл Засгийн газарт байхгүй. Төрийн байгууллагууд салбарын хуулийнхаа хүрээнд тус бүрдээ бүртгэлтэй байна.
- Хувь хүний өгөгдөл, мэдээллийг нэргүйжүүлж нийтлэх нийтлэг хууль, журам байдаггүй.
- + Хувь хүний нууцад хамаарах өгөгдөл, мэдээллийг хамгаалах, нэргүй болгох талаар ҮСХ-ны дотоод журам, аргачлал байдаг.

## 2.2 Мэдээлэл авах ямар эрхүүд байдаг вэ? (Ач холбогдол: Маш өндөр)

- + Үндсэн хуулийн 16.17 дугаар заалт, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээд нууцад хамааруулснаас бусад бүх мэдээллийг авах эрхтэй.
- + Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу төрийн мэдэлд байгаа нууцад хамаарахгүй аливаа мэдээллийг иргэн тухайн мэдээлэл байгаа төрийн аливаа байгууллагад бичгээр хүсэлт гарган авч болдог.
- + Төрийн мэдээллийг цахим хэлбэрээр авахад төлбөргүй.
- o Иргэн, хувь хүн мэдээлэл авах процессыг төрийн байгууллагууд тус бүрдээ хариуцдаг.
- o Мэдээлэл авах хүсэлтэд мэдээлэл өгөх хуулийн үүргээ төрийн байгууллага бүхэлдээ сайн мөрддөг болсон.
- Мэдээлэл авах тогтолцооны дагуу ямар мэдээлэл хэр их өгсөн бүртгэл төрийн байгууллагуудад байхгүй байна. Гэвч өгөгдлийн эрэлт тодорхой хэмжээгээр бий болсон байна.

### 2.3 Өгөгдлийн аюулгүй байдал, өгөгдөл архивлах болон тоон хэлбэрт хадгалах тухай хууль эрх зүйн болон бодлогын орчин ямар вэ? (Ач холбогдол: Өндөр)

- + Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг ХХМТГ, хэрэгжилтийг Тагнуулын ерөнхий газар (ТЕГ) хариуцдаг.
- + Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг<sup>15</sup> 2010-2015 онд хэрэгжүүлсэн.
- + Архивын ерөнхий газар (АЕГ) цаасан болон цахим хосолсон хэлбэрээр албан өгөгдлийн архивлаж хадгалдаг. Цахим архивын бодлого журмыг ХХМТГ хариуцан АЕГ-тай хамтарч ажилладаг.
- + Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолын захиргааны байгууллагын цахим мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтад тавигдах шаардлагад захиргааны байгууллага нь мэдээллийн сангийн нөөцийг тогтмол шинэчилж, архив үүсгэж байх гэж заасан байдаг.
- “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм” /MNS/ISO 17799:2007/, “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага” /MNS/ISO 27001:2007/ зэрэг мэдээллийн аюулгүй байдлын талаар 13 стандарт байдаг. Тогтоол шийдвэр, дүрэм журам батлагдахдаа стандартыг хангаж ажиллахыг үүрэг болгодог боловч хэрэгжилт сул байдаг.
- + ТЕГ нь мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг төрийн байгууллагуудад мөрдүүлэн хэрэгжилтэд хяналт тавьдаг.
- + Төрийн байгууллагуудад байршиж байгаа цахим бүртгэл, мэдээллийн санг ҮДТ-д шилжүүлэн байршуулах тухай Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолыг мөрдөж байна. Тус байгууллага мэдээллийн аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар хангаж ажилладаг туршлага бий.

---

<sup>15</sup> Засгийн газрын 2010-06-02-ны өдрийн 141 дүгээр тогтоол, <http://legalinfo.mn/law/details/4716>, хандсан: 2018-06-05

## 2.4 Төрийн өгөгдлийг эзэмших, зөвшөөрөл олгох талаар ямар бодлого байдаг вэ? (Ач холбогдол: Маш өндөр)

- Төрийн өгөгдлийн эзэмшлийг хууль, журамд тодорхой заагаагүй боловч өгөгдлийг үүсгэгч өгөгдлийг эзэмшдэг. Гэвч дээд шатны удирдах байгууллага харьяа байгууллагын өгөгдлийг чөлөөтэй авах, эзэмших тогтсон туршлага бий.
- Засгийн газраас төрийн өгөгдлийн эзэмшил, ашиглах зөвшөөрлийг зохицуулсан тогтоол шийдвэр гаргаж байгаагүй.
- + Төрийн байгууллага бусад байгууллагад өөрийн өгөгдлийг өгөх, эзэмшүүлэх зөвшөөрлийг санамж бичиг болон гэрээний хүрээнд олгодог туршлага байна.
- Өгөгдөл, мэдээллийн ашиглах нөхцөл шаардлагыг эзэмшигч байгууллага ерөнхийдөө тогтоодог боловч ашиглах нөхцөл шаардлагыг хууль дүрэмд нийцүүлэн нарийн тодорхойлохгүйгээр түгээдэг тохиолдол байна.
- + Төрийн өгөгдөл ашиглалтыг зохицуулах Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг бүрдүүлэх ашиглах” журам байдаг.
- Төрийн өгөгдлийг ашиг олох зорилгоор ашиглуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомж, зохицуулалт одоогоор байхгүй байна.
- Засгийн газрын гэрээ, худалдан авах ажиллагааны хүрээнд өгөгдлийн өмчлөлийг шийдэх нэгдсэн бодлого, дүрэм журам байхгүй.
- Төрийн байгууллага гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний хүрээнд өгөгдлийн эзэмшлийг зохицуулах боломжтой байдаг. Гэвч гэрээний нөхцөлд өгөгдлийн эзэмшил, ашиглах нөхцөл шаардлагыг тусгайлан зааж өгдөггүй байна.
- Захиалагч байгууллага өгөгдлийн өмчлөлийг шийдвэрлэнэ гэдэг ойлголт төрийн байгууллагад нийтлэг байна.
- Өгөгдлийг нээлттэй ашиглах зөвшөөрлийг (Creative Commons гэх мэт)

дотоодын хөрсөнд буулгасан, нэвтрүүлсэн туршлага байхгүй.

## 2.5 Төрийн байгууллагууд төрийн өгөгдлийг хэр зэрэг борлуулдаг вэ? (Ач холбогдол: Маш өндөр)

- Төрийн өгөгдөл, мэдээллийн үнэ, төлбөрийг тогтоох тухай албан ёсны бодлого, хуулийн зохицуулалт байхгүй.
- + Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1, 16.2, Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, хөнгөлөх, чөлөөлөх<sup>16</sup> журмаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
- + Төрийн мэдээллийн төлбөрийг тогтоох асуудлыг УИХ эсвэл Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу дагаж мөрдөнө.
- + Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) зэрэг байгууллагууд өөрийн өгөгдлийг албан ёсоор борлуулдаг. Өгөгдөл борлуулсан орлого тухайн байгууллагын төсөв бүрдүүлэхэд бага нөлөөлдөг байна.
- o Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын дунд албан бусаар өөрийн өгөгдлийг борлуулдаг туршлага байхгүй.
- + ҮСХ нэргүй болгосон, нэмэлт боловсруулалт хийсэн өгөгдөл борлуулдаг. Гэвч нэргүй болгосон өгөгдлийн үнэ цэнэ буурдаг тул өгөгдлийн хэрэглэгч нэргүй болгоогүй хувилбарыг авах сонирхолтой байдаг.
- + Нэргүй болгоогүй хувийн өгөгдөл, мэдээллийг борлуулдаг байгууллага байхгүй.

---

<sup>16</sup> Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам, <http://www.legalinfo.mn/annex/details/5805?lawid=9104>, хандсан: 2018-3-10

## 2.6 Нээлттэй өгөгдөлд чухал нөлөөлөхүйц бусад бодлого/хууль тогтоомж байна уу? (Ач холбогдол: Өндөр)

- + Нээлттэй өгөгдөлд нөлөөлөхүйц Төрийн болон албаны нууцын тухай хууль<sup>17</sup> байдаг. Энэ хуулиар албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлохыг заасан байдаг учир өгөгдлийг нээх асуудлыг тухайн байгууллага шийдвэрлэх боломжтой.
- + Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох асуудлаар ТЕГ санал боловсруулж Засгийн газарт оруулдаг. Нууцыг ил болгох журмыг Засгийн газар баталдаг. Мөн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 19-р зүйлд нууцыг ил болгох үндэслэлийг тодорхойлсон байдаг. Үүнд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон бол нууцаас гаргах заалт бий.
- + Өгөгдөл, мэдээллийг албаны нууцад хамааруулах, нууцаас гаргах асуудлыг тухайн байгууллага хариуцдаг. Албаны нууцад хамааруулснаас бусад өгөгдлийг үүсгэгч болон/эсвэл эзэмшигч байгууллага нийтлэх боломжтой.
- + Үндэсний статистикийн өгөгдөл, мэдээллийг нийтлэх асуудлыг Статистикийн тухай<sup>18</sup> хуулиар зохицуулдаг. ҮСХ-ны дотоод хуваарийн дагуу статистикийн өгөгдлийг нийтэлдэг.
- Концессын тухай хуулиар төрийн үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох хууль зүйн зохицуулалт байдаг боловч өгөгдлийн бүрдлийг ашиглах, нийтлэх, түгээхтэй холбоотой онцгой зохицуулалт байхгүй.
- Хувийн нууцад хамааралгүй төрийн өгөгдөлд (жишээ нь, компанийн бүртгэл, бизнесийн статистик өгөгдөл) хандах гуравдагч этгээдийн эрхийн талаар эсвэл нууцлалыг хангах хуулийн зохицуулалт байхгүй.
- + Мэдээллийг архивлах болон цахим мэдээллийг хадгалах талаар Архивын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолыг мөрдөж ажилладаг.

<sup>17</sup> Төрийн болон албаны нууцын тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/12408>, хандсан: 2018-04-01

<sup>18</sup> Статистикийн тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/461>, хандсан: 2018-04-01

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Хувийн нууцыг хамгаалах	Маш өндөр	УЛААН	Хувь хүний нууцыг хамгаалах хуультай боловч түүний хэрэгжүүлэх механизм сул, нэгдсэн бүртгэл байхгүй байна. Ялангуяа цахим өгөгдөлд хувийн нууцыг хамгаалах асуудал орхигдсон.
Мэдээлэл авах эрх	Маш өндөр	НОГООН	Мэдээлэл авах эрхийн тухай хууль байгаа.
Өгөгдөл хамгаалал, архивлах, тоон хэлбэрт хадгалалт	Өндөр	ШАР	Өгөгдөл хамгааллын хуулийн зохицуулалт байхгүй.
Өгөгдөл эзэмшил, зөвшөөрөл	Маш өндөр	УЛААН	Өгөгдлийн эзэмшлийн нэгдсэн бодлого зохицуулалт байхгүй. Байгууллага тус бүр өөрийн өгөгдлийг эзэмших асуудлыг хариуцан ажилладаг учир байгууллагын шийдвэрүүд харилцан адилгүй.
Өгөгдөл борлуулалт	Өндөр	ШАР	Албан ёсоор төрийн өгөгдөл борлуулдаг байгууллага маш цөөхөн бөгөөд өгөгдлийн үнэ цэнийг тодорхойлсон хууль, дүрэм журам болон нэгдсэн бодлого байхгүй.
Бусад хууль тогтоомж	Өндөр	ШАР	Төрийн болон албаны нууцын тухай, Статистикийн тухай хуулиуд байдаг. Харин төрийн өгөгдлийг гуравдагч этгээдийн өмчлөл, ашиглах зохицуулалт байхгүй.
<b>НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ</b>		<b>ШАР</b>	<b>Нээлттэй өгөгдлийг үүсгэхэд хуулийн талаас тулгарах саад, бэрхшээлгүй боловч нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөл, зөвшөөрөл тодорхойгүй.</b>



### 3 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ТӨРИЙН ХАРИУЦЛАГА, ЧАДАМЖ

**Ач холбогдол:** Өндөр

**Агуулга:** Улс төрийн болон дээд шатны удирдлагын манлайллаас гадна дунд түвшний удирдлагын чадвар, манлайлал Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал байдаг. Үүнд төрийн байгууллагууд өгөгдлийг цуглуулах, аюулгүй байдлыг хангах, чанарт хяналт тавих болон нийтлэх зэрэг ажлуудыг ил тод менежмент, сайн зохион байгуулалттай процессоор удирдах шаардлагатай. Эдгээр ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төрийн байгууллага нь өгөгдлийн менежментийн тодорхой бизнес процесс, өгөгдлийн тухай техникийн зөв ойлголт (жишээ нь формат, мета-өгөгдөл, API, өгөгдлийн сан), МХТ-ийн мэдлэг, ур чадвар өндөр албан хаагчидтай байх хэрэгтэй. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өгөгдлийг “нийлүүлэгчтал” – төрийн байгууллага, агентлагууд нээлттэй өгөгдлийг ашиглах (дахин ашиглах) сонирхлын бүлэг болох програм хөгжүүлэгч, компаниуд, төрийн бус байгууллагууд, бусад төрийн байгууллага болон жирийн иргэдийн оролцоог хангах бүтэц, чадвартай байх хэрэгтэй байдаг.

#### **3.1 Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулахад аль агентлаг, байгууллага холбогдох чадавх, чиг үүрэг, төслийн менежментийн туршлага, техникийн ур чадвартай байна вэ? (Ач холбогдол: Маш өндөр)**

- + Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийг төрийн хэмжээнд бүхэлд нь удирдаж ажиллах улс төрийн эрх мэдэл, дэмжлэг үзүүлэх боломж ЗГХЭГ болон ХХМТГ-т байна.
- + Үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрийн хувьд ЗГХЭГ төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа, хамтын ажиллагааны нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулах, МХТ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх

үүрэгтэй оролцдог туршлага бий. Одоогоор төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг энэ загвараар хэрэгжүүлж эхлээд байна.

- Үндэсний хэмжээнд сул хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хувьд удирдлагын хүсэл зориг, хүчин чармайлт, удирдлагын манлайлал дутагдалтай байсан бөгөөд энэ нь Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн хувьд давтагдах эрсдэлтэй байна.
- + Төрийн агентлаг, албан хаагчдад нээлттэй өгөгдлийг нэвтрүүлэх, хэвшил болгох талаар МТҮП, ХХМТГ, ЗГХЭГ 2014-2016 онд нээлттэй өгөгдлийг танилцуулах, сурталчлах чиглэлээр ажиллаж байсан. Засгийн газрын 2020 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийн талаар 2 зорилт орсон байдаг ба нээлттэй өгөгдлийг дэмжих байр суурьтай байгаа.
- Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх гол байгууллагуудын удирдлага хурдан солигддог учраас урт хугацаанд хэрэгжих МХТ-ийн төсөл, хөтөлбөр тогтвортой хэрэгжихгүй байна.
- + ҮСХ, Сангийн яам, БОАЖЯ, ТӨБЗГ одоогоор нээлттэй өгөгдлийг<sup>19,20,21,22</sup> тодорхой хэмжээнд, цахим хэлбэрээр нийтлээд байна. УБЕГ, Татварын ерөнхий газар (ТатЕГ), ГЗБГЗЗГ гол оролцогчид байх боломжтой.

### **3.2 Өгөгдлийн менежмент хариуцсан мэдээлэл хариуцсан захирал (CIO – Chief Information Officer), технологи хариуцсан захирал (CTO – Chief Technology Officer) эсвэл өгөгдлийн менежментийн асуудал хариуцдаг байнгын ажлын байр бүхий ямар агентлагууд байна вэ? (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- o Мэдээлэл технологийн асуудал хариуцсан захирлын үүрэг бүхий байнгын ажлын байр төрийн зарим байгууллагад байдаг хэдий ч эрх мэдэл, албан тушаалын хувьд олон улсад байдаг CIO/CTO албан тушаалтай адилгүй байна.

<sup>19</sup> Үндэсний статистикийн хорооны нээлттэй өгөгдөл, <http://opendata.1212.mn/mn/doc>, хандсан: 2018-04-12

<sup>20</sup> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын нээлттэй өгөгдөл, <http://opendata.tender.gov.mn/>, хандсан: 2018-02-18

<sup>21</sup> Шилэн дансны цахим систем, <http://shilendans.gov.mn/>, хандсан: 2018-02-18

<sup>22</sup> Байгаль орчин аялал жуулчлалын яам, <https://www.mne.mn/>, хандсан: 2018-02-22

- Төрийн ихэнх байгууллагад өгөгдлийн менежментийн асуудал хариуцсан байнгын ажлын байр байхгүй.
- + ҮСХ, ТатЕГ, УБЕГ зэрэг томоохон мэдээллийн системтэй, өгөгдлийг их хэмжээгээр бүрдүүлэгч байгууллагууд өгөгдлийн менежментийн асуудлаар тодорхой туршлагатай байна.

### **3.3 Ямар механизмаар агентлаг хоорондын МХТ-ийн асуудлыг (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- Яам, агентлагуудын мэдээллийн системийн бодлого, менежментийг бүхэлд нь хариуцдаг байгууллага байхгүй. Байгууллага бүр өөрийн мэдээллийн системийн хөгжүүлэх асуудлыг хариуцдаг.
- + Төрийн байгууллага, агентлаг хоорондын нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системийг нэвтрүүлэх ажлыг ЗГХЭГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн үндэсний зөвлөлийн санаачилгаар хэрэгжүүлж байна.
- + Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолын дагуу төрийн байгууллагуудад байрладаг цахим бүртгэл, мэдээллийн санг ҮДТ-т шилжүүлэн байршуулсан байдаг. Эдгээр бүртгэл, мэдээллийг төрийн нэгдсэн сүлжээгээр төрийн байгууллага хооронд дамжуулдаг ба энэ сүлжээг ТЕГ-ийн харьяа Төрийн мэдээлэл, холбооны газар хариуцдаг. Харин өгөгдлийн стандарт болон бусад техникийн асуудлыг ҮДТ хариуцан ажиллаж эхэлсэн.
- Системийн архитектур, өгөгдлийн нэгтгэл, чанарын хяналт, түгээх дамжуулах, өгөгдлийн зохицол зэрэг асуудлыг шийдвэрлэж ирсэн нэгдсэн туршлага, зохицуулалт байхгүй.
- + ЗГХЭГ, ХХМТГ, ҮДТ, ТатЕГ, УБЕГ зэрэг байгууллагууд төрийн байгууллагуудын өгөгдөл солилцох механизмд идэвхтэй оролцоотой.

### **3.4 Байгууллагын үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн үзүүлэлтийг ямар процессоор хэмждэг вэ? (Ач холбогдол: Дунд)**

- + Төрийн гүйцэтгэлийн менежментийг төрийн байгууллага, агентлагууд тус

тусдаа үр дүнгийн гэрээ, түүний биелэлтээр хэрэгжүүлдэг уламжлалт тогтолцоо бий. Гүйцэтгэлийн үр дүнгийн мэдээллийг ЗГХЭГ нэгтгэдэг.

- МХТ-ийн болон үйлчилгээний гүйцэтгэлийн менежмент байхгүй.

### **3.5 Аль яам эсвэл агентлаг статистик мэдээ эсвэл өгөгдлийг анхлан хариуцдаг вэ? (Ач холбогдол: Дунд)**

- + ҮСХ нь 1212.mn цахим хуудсаараа татаж авах боломжтой, дахин ашиглах форматтай нээлттэй өгөгдөл нийтэлдэг, гэвч эдгээр нь нээлттэй эхийн лицензгүй байдаг.
- + ҮСХ өгөгдлийг системтэйгээр цуглуулах, цэвэрлэх гэх мэт менежментийн тогтсон механизмыг хэрэгжүүлж өгөгдлийг хариуцдаг процесстой.
- + ҮСХ өгөгдлийн менежментийн талаар сайн туршлагатай. Тухайлбал, тооллого, судалгааны мэдээллийн санг бүрдүүлэхэд тогтсон дүрэм журамтай байна.
- + ҮСХ-ны 1212.mn цахим хуудсанд нийт 736 хүснэгтэн өгөгдөл дахин ашиглах нээлттэй форматаар нийтлэгдсэн.

### **3.6 Өгөгдөл гаргах талаар аль агентлаг эсвэл яам хамгийн их үүрэг хариуцлага хүлээдэг вэ? Тэдний үндсэн сонирхол юу вэ? Шат дамжлагыг хэрхэн зохицуулж байгаа, тухайн байгууллагын сонирхолтой хэрхэн тохирч байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + Өөрийн өгөгдөл гаргах талаар ҮСХ болон ТӨБЗГ, БОАЖЯ, ГЗБГЗЗГ зэрэг байгууллагууд өөрийн санаачлагаар өгөгдлөө нээлттэйгээр нийтэлдэг. Нийтлэх болсон үндсэн сонирхол нь тухайн байгууллагын үүсгэж байгаа өгөгдөл олон нийтэд нээлттэй байх шаардлагатай гэдэг үүднээс нээлттэй болгосон байдаг. Өгөгдлийг нийтлэх шат дамжлагыг аль болох хүнээс хамааралтайгүйгээр мэдээллийн системээс автоматаар нийтэлдэг.

### **3.7 Төрийн дээд шатны удирдлага, төрийн албан хаагчдын дунд төрийн МХТ-ийн ур чадвар хэр сайн байдаг вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- Төрийн албаны зөвлөлд төрийн удирдах албан тушаалтнуудын цахим

боловсролын түвшнийг тодорхойлсон судалгаа байдаггүй. Төрийн албан хаагч болох шалгалтад шалгуулагчдын ихэнх хувь нь цахим ур чадварын шалгалт хангалтгүй үнэлгээ үзүүлсэн байна. Энэ шалгалтаар цахим бичиг баримт боловсруулах, компьютерийн хэрэглээний анхан шатны түвшнийг үнэлдэг.

- Төрийн албан хаагчид МХТ, өгөгдлийн стандарт эсвэл өгөгдлийн анализ сургалтыг аль ч түвшинд явуулаагүй байна.
- Төрийн албан хаагчдын МХТ-ийн ур чадварын үнэлгээ хийдэггүй.
- Төрийн албан хаагчдын зэрэг дэв болон урамшууллын асуудлыг шийдвэрлэхэд МХТ-н ур чадварыг тусгадаггүй. Ажилласан жил, ажлын туршлагад үндэслэн шийдвэрлэдэг уламжлалт туршлага бий.

### **3.8 Засгийн газрын цахим вэб дэх орон зай ямар вэ? (Ач холбогдол: Дунд)**

- Монголын IRIM бие даасан судалгааны байгууллага сүүлийн 4 жил төрийн цахим хуудасны ил тод байдлын судалгаа<sup>23</sup> гүйцэтгэж байгаа бөгөөд 2017 оны хамгийн сүүлийн судалгаагаар төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал 58.4 хувь, мэдээллийн найдвартай байдал 55.3 хувь, цаг үеийн мэдээллийн хоцролгүй оруулдаг байдал 38.5 хувь, мэдээллийн хүртээмжтэй байдал 59.6 хувь болон хэрэглэхэд хялбар байдал 68.5 хувь гэсэн байгаа нь засгийн газрын вэб дэх орон зайн байдал дундаж үзүүлэлттэй, сайжруулах зүйл их байгаа нь харагдаж байна.

---

<sup>23</sup> Вэб мониторинг, <http://www.irim.mn/web-monitoring>, хандсан: 2018-04-22

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Боломжит байгууллага	Маш өндөр	ШАР	Үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх засаглалын загвар, туршлага байна. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг тогтвортой манлайлах удирдагч тодроогүй байна.
Өгөгдлийн менежментийн чадавх	Дундаас өндөр	ШАР	Өгөгдөл эзэмшигч гол агентлагуудын хувьд мэдээллийн технологи хариуцсан удирдах албан тушаалтан байгаа хэдий ч CIO/CTO үүрэгтэй адилгүй бөгөөд өгөгдлийн менежмент, эрх мэдэл, туршлага болон идэвх сул байна.
МХТ-ийн нэгдмэл байдал	Дундаас өндөр	ШАР	Технологийн хатуу дэд бүтцийн хувьд бэлэн байгаа боловч байгууллага бүр бие даасан бодлого, үйл ажиллагаатай байна.
Гүйцэтгэлийн үнэлгээ	Дунд	ШАР	Ерөнхий гүйцэтгэлийн үнэлгээний механизм байгаа боловч МХТ-ийн гүйцэтгэлийн менежмент байдаггүй.
Өгөгдөл/Статистик хариуцсан байгууллага	Дунд	ШАР	Статистикийн өгөгдөл хариуцсан нэгдсэн байгууллагын үйл ажиллагаа маш сайн, төрийн бусад өгөгдлийн менежментийн тогтсон механизмыг хэрэгжүүлж өгөгдлийг хариуцдаг нэгдсэн газар байхгүй.
Өгөгдөл нээх сонирхол	Өндөр	ШАР	ҮСХ, СЯ, БОАЖЯ, ТӨБЗГ зэрэг байгууллага өгөгдөл нээх сонирхол маш өндөр, төрийн бусад байгууллагуудын хувьд сонирхол бага байна.
МХТ-ийн ур чадвар	Өндөр	УЛААН	Төрийн дээд болон дунд

			шатны удирдах албан тушаалтан, албан хаагчдын ур чадварын үнэлгээ тогтмол хийдэггүй.
Төрийн цахим орон зай	Дунд	ШАР	Төрийн вэб орон зайн үзүүлэлт дундаж байна.
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		ШАР	Өгөгдлийн менежмент болон МХТ-ийн ур чадварыг сайжруулахад анхаарч гүйцэтгэлийг үнэлэх шаардлагатай байна.

## 4 ТӨРИЙН ӨГӨГДЛИЙН МЕНЕЖМЕНТ, ӨГӨГДЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

**Ач холбогдол:** Өндөр

**Агуулга:** Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг засгийн газар доторх мэдээллийн менежментийн үйл ажиллагаа болон цахим өгөгдлийн эх үүсвэрүүд бүрдсэн үед хэрэгжүүлдэг. Өгөгдөл нь зөвхөн цаасан хэлбэрээр байгаа тохиолдолд Нээлттэй өгөгдөл болгон, дахин ашиглах боломжтой форматаар хурдан, бага зардлаар нийтлэхэд хүндрэлтэй юм. Гэвч засгийн газарт мэдээллийн менежментийн сайн туршлага байгаа бол өгөгдөл, түүний мета-өгөгдөл болон холбогдох бичиг баримтыг олох, өгөгдөл эзэмшигчийг тодорхойлох ажлыг илүү хялбар хийх боломжтой. Мөн нээлттэй өгөгдлийг нийтэд түгээхэд шаардлагатай байгаа зүйлсийг үнэлэх, өгөгдлийг тогтвортой нийтлэх үйл ажиллагааг зүгшрүүлж хэвийн явуулах нь мэдээллийн менежментийн өдөр тутмын ажлын нэг хэсэг болдог. Гол өгөгдлийн бүрдлийн хувьд, бэлэн байдлын үнэлгээ нь тэдгээр өгөгдлийн бүрдэл бэлэн байгаа эсэх болон эсвэл тэдгээрийг нээлттэй болгоход юу хийх шаардлагатай болохыг тодорхойлно. Ямар өгөгдлийн бүрдэл нэн тэргүүнд нээлттэй болгох нь тухайн орны нөхцөл байдлаас хамаарах тул улс төрийн өргөн хүрээнд дэмжлэг авах эсвэл үндэсний тэргүүлэх чиглэлд тулгуурласан тэдгээрийн хэрэглээний хувьд илүү дэмжлэг авч чадахаас шалтгаална. Нээлттэй өгөгдлийн үндсэн зорилт – эдийн засгийг өсгөх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах болон нээлттэй засаглал, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд тодорхой өгөгдлийн бүрдлүүд онцгой нөлөөтэй болохыг бусад оронд хэрэгжиж байгаа Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн туршлагаас харж болно. Тэдгээр өгөгдлийн бүрдлийг Дэлхийн банкны Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээний аргачлалд дурдсан байдаг. Бусад өгөгдлийн бүрдлийг өмнө нь хийж гүйцэтгэсэн бэлэн байдлын үнэлгээний тайланд туссан байдал, улс, салбар, байгууллагын дотоод нөхцөл байдалд үндэслэн тодорхойлж болно. Тухайлбал, усны нөөц, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, байгалийн баялгийн олборлолт, гамшгийн бэлэн байдал болон түүний удирдлага гэх мэт юм.



#### **4.1 Төрийн мэдээллийн менежментийн бодлого, үйл ажиллагаа ямар байдаг вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тухайн байгууллагад байгаа нууцын зэрэглэлтэй мэдээллийг байгууллагын нууц хариуцсан ажилтан хариуцах бөгөөд хэрэгжилтийг ТЕГ хариуцдаг. Засгийн газрын 2017 оны 159 дугаар тогтоолд төрийн байгууллага өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хариуцахыг заасан хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.
- Антивирус програм үйлдвэрлэгч Касперски Лаб байгууллагын 2018 оны тайланд Монгол Улсын төрийн цахим аюулгүй байдал хамгийн эмзэг гэж дурдсан нь өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үр дүнг илтгэж байна.
- + Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар өгөгдлийг нээлттэй болгох боломжийг бий болгосон.
- Харин өгөгдөл хамгааллын харилцааг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй тул нээлттэй байж болох өгөгдлийг тодорхойлоход эргэлзээг бий болгон саад учруулах боломжтой.
- Өгөгдлийн чанар – баталгаажсан, үнэн зөв, шинэчлэгдсэн, бүрэн байдлыг тодорхойлсон стандарт, бодлого байхгүй.
- + Төрийн албан ёсны хэлний тухай хуулиар Монгол хэл албан ёсны ганц хэл юм.
- + 2016-2020 он хүртэлх Засгийн газрын бодлого, мөрийн хөтөлбөрийн хүрээнд төрийн ил тод байдал, төрийн үйлчилгээг сайжруулахад нээлттэй өгөгдөл маш үр дүнтэй, үнэлгээний зорилготой бүрэн нийцэж байна.

#### **4.2 Төр өөрийн өгөгдлийн талаар хэр бодитой ойлголттой байна вэ? (Ач холбогдол: Дунд)**

- Засгийн газрын түвшинд өгөгдлийн нэгдсэн бүртгэл байхгүй. Төрийн байгууллагын хувьд үйл ажиллагааныхаа хүрээнд тодорхой өгөгдлийн бүртгэлтэй байдаг. Гэвч өгөгдлийн формат, мета-өгөгдөл, өгөгдлийн баримт

бичгийн бүрдүүлэлт хангалтгүй.

- + ҮСХ тооллого судалгааны каталог, статистик өгөгдлийн бүртгэлийг бүрдүүлсэн байдаг.
- Цахимжсан үйлчилгээ, үйл ажиллагааны хувьд өгөгдөл ерөнхийдөө бүрэн байдаг. Харин өгөгдлийн шинэчлэл, үнэн зөв байдлыг хангах тал дээр төрийн байгууллагууд сул байна.
- Төрийн байгууллагын дунд өгөгдлийг анхдагч эх сурвалжаас авч ашигладаг бодлогын болон засаглалын тогтолцоо сайн хөгжөөгүй учир өгөгдөл зөрүүтэй хадгалагдаж байгаа тохиолдол их байна.
- Төрийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх мета-өгөгдлийн нэгдсэн стандарт байхгүй.
- + ҮСХ өгөгдлийн бүртгэлийг мета-өгөгдлийн хамт дэлгэрэнгүй хадгалдаг.
- + Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмын<sup>24</sup> 2.1.3 заалтаар нийтлэг үндсэн гол өгөгдлийн бүрдлийг жагсаасан байдаг.
- Засгийн газрын бүх шатанд хэрэглэгддэг суурь өгөгдлийн бүрдлийг шууд авч ашиглах боломжгүй. Өгөгдлийн бүртгэл, каталог, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй, зөвхөн байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээрийн үр дүнд авч ашигладаг.

#### **4.3 Төрийн өгөгдлийг хаана, хэрхэн байршуулдаг вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + ҮДТ дээр төрийн ихэнх байгууллагын цахим өгөгдлийг бүрэн болон хуулбар хэлбэрээр байршуулдаг.
- Байршуулсан өгөгдлийн төрөл, хэмжээ, форматын хувьд хийсэн судалгаа байхгүй.
- + АЕГ хуучирсан цаасан, дуу дүрс бичлэг, зураг зэрэг өгөгдлийг цахим хэлбэрт оруулж архивын бүртгэл үүсгэсэн байна.

---

<sup>24</sup> Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам, <http://www.legalinfo.mn/annex/details/7897?lawid=12739>, хандсан: 2018-04-26

- Төрийн бусад байгууллагын хувьд хуучирсан өгөгдлийг цахим болгож ашигладаг туршлага ховор байна.
- Төрийн баримт бичиг төлбөртэй програмын файлын форматтай байдаг.
- + Гол мэдээллийн системүүд Oracle өгөгдлийн сангийн удирдах систем ашигладаг. Энгийн хэрэглээ, тухайлбал вэб хуудасны өгөгдөл нээлттэй эхийн төлбөргүй системийн форматтай байна.
- + Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн ХУР системээр төрийн зарим байгууллагууд өгөгдөл солилцож эхлээд байна.
- + Төрийн байгууллагад ашиглагддаг техникийн хүчин чадал, технологийн хувьд өгөгдлийг нээлттэй болгоход саад бэрхшээл байхгүй.
- + Ихэнх төрийн байгууллагууд үйлчилгээ, дотоод үйл ажиллагаандаа мэдээллийн системийг ашигладаг болсон тул техник технологийн хувьд өгөгдлийг хүний оролцоо бага, автоматаар нийтлэх боломж байна.
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн байдалд мониторинг, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах тухай заасан байдаг боловч журам байхгүй гэрээгээр зохицуулж явдаг.
- Төрийн байгууллагуудын дунд өгөгдлийн эзэмшил, ашиглах зөвшөөрөл болон өгөгдөлд хандах эрх, өгөгдлийг ашиглах нөхцөл, өгөгдлийг түгээхтэй холбоотой ойлголт хангалтгүй байна.
- + Үйл ажиллагааны түвшинд ашиглахаа больсон өгөгдлийг MNS:15489 стандартын дагуу АЕГ-аас боловсруулсан журам, стандарттай уялдуулан Архивын тухай хуульд заасан өгөгдлийг цахим хэлбэрээр архивладаг.
- + Архивын тухай хуульд заагаагүй бусад цахим өгөгдлийг ҮДТ цахим архивын журам мөрддөг.

#### **4.4 Төрийн байгууллагуудын дотоод болон бусад байгууллага хоорондын өгөгдлийн бодит болон далд эрэлт хэр байдаг вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + Төрийн ижил түвшний яам агентлагууд төрийн нэгдсэн сүлжээгээр холбогдож өгөгдлөө солилцдог.
- + Өгөгдөл солилцохдоо байгууллага хооронд гэрээ байгуулж хэрэгжүүлдэг. Өгөгдөл солилцох үйл ажиллагаа бүрийн хувьд гэрээ байгуулах нь хүндрэлтэй байдаг.
- Төрийн өөр өөр түвшний байгууллага хооронд үйл ажиллагаандаа нэн шаардлагатай өгөгдлийг солилцдог. Гэвч олон төрлийн өгөгдлийг чөлөөтэй солилцож чаддаггүй.
- Төрийн байгууллага бусад төрийн байгууллагаас нийтлэг гол өгөгдлийн бүрдэл авахдаа албан бичгээр харилцаж шийдүүлж байгаа нь хүндрэлтэй байна.
- Төрийн байгууллагуудад өгөгдлийн нэгдсэн ангилал зүй байдаггүй.
- + ҮСХ статистик өгөгдлийг бусад байгууллагаас цахим шуудангаар цуглуулдаг.
- + ҮСХ-ны статистик өгөгдлийг мэдээллийн системээс шууд хандаж авах (API, web service) боломжтой.
- Төрийн байгууллага бусад байгууллагын үйл ажиллагааны болон статистик мэдээллийг олж авахдаа цаасан тайлан, вэб сайт эсвэл цахим шуудангаар авдаг.
- Судалгааны өгөгдлийг захиалгаар төрийн бус байгууллагаас цуглуулж худалдаж авч байсан туршлага байдаг. Харин хувийн хэвшлийн байгууллагаас өгөгдөл худалдаж авч байсан туршлага, тохиолдол төрийн байгууллагын дунд байхгүй байна.

#### **4.5 Ямар өгөгдөл үнэ төлбөргүй эсвэл төлбөртэй, ямар нөхцөлтэй нийтэд нээлттэй байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + ҮСХ-д одоогоор 700+ нээлттэй өгөгдлийн бүрдлийг CC-BY 4.0 лицензтэй

нийтэлсэн байна. Эдгээрээс өгөгдлийн бүрдлийн формат дахин ашиглахад бүрэн боломжтой JSON, CSV, болон Microsoft Excel форматаар байна. HTML өгөгдлийн бүрдэл цөөхөн байдаг.

- + ҮСХ, ТӨБЗГ-ын нээлттэй өгөгдлийн бүрдлүүдийг API болон файлаар авах боломжтой. Бусад байгууллагын нээлттэй өгөгдлийн бүрдлийн хувьд файлаар авах боломжтой.
- + Төрийн байгууллагууд өгөгдөл зарж орлого олдог туршлага зарим байгууллагад бий. Тухайлбал, цаг агаарын архив болон газрын зургийн өгөгдлийг зарж борлуулдаг.
- Зарж борлуулдаг өгөгдлийг цааш дамжуулахгүй, зарж борлуулахгүй байх гэсэн үндсэн заалтаас өөрөөр илүү нарийвчилсан нөхцөл, шаардлага тавьж өгдөггүй.
- o Төрийн ихэнх байгууллагын вэб сайтаас татаж авч болох өгөгдөл ихэвчлэн PDF, DOC(X) төрлийн форматтай байдаг. Ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6.1 заалтын дагуу байгууллагууд төсөв санхүү, үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авах ажиллагааны мэдээллийг ил тод болгож, татаж авах эсвэл зөвхөн харах боломжтойгоор байршуулдаг.

#### **4.6 Хувийн мэдээллийн чанартай өгөгдлийг нэргүй болгох талаар төрийн ямар практик, туршлага байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + ҮСХ дотоод ажлын хүрээнд мэдээлэл боловсруулахад тодорхой аргачлалын дагуу нэргүй болгодог.
- ҮСХ-ээс бусад төрийн байгууллагууд хувийн мэдээллийг нэргүй болгох туршлага байхгүй.
- + Өгөгдлийг нэргүй болгоход хэрэглэдэг стандартгүй.
- + Бусад өгөгдлийн эх үүсвэрээс гаргасан нэргүй болсон өгөгдлүүдийг ашиглан ямар нэг хувь хүний хувийн мэдээллийг олж авсан мэдэгдэж байгаа туршлага одоогоор байхгүй байна.

**4.7 Өгөгдлийн удирдлагын чадавхыг нэвтрүүлсэн ямар төрийн байгууллага (Жишээ нь, ҮСХ гэх мэт) өргөн хүрээний хөтөлбөрийн манлайллыг хангах боломжтой вэ? Одоогийн хэрэгцээт чадавх нь: (Ач холбогдол: Дунд)**

- + ҮСХ нь л өгөгдөл цуглуулах, арчилж хадгалах, удирдах, нийтлэх зэрэг өгөгдлийн удирдлагыг сайн нэвтрүүлсэн байгууллага.
- Ихэнх төрийн байгууллагууд нь мэдээллийн системтэй болсон ч өгөгдлийн удирдлага хангалтгүй.
- + ҮСХ нь өгөгдлийн удирдлагад өгөгдлийг баримтжуулж, стандарт ажлын урсгалыг тодорхойлж ажилладаг.
- + ҮСХ өгөгдлийн шинжилгээ хийж статистик мэдээллийн боловсруулдаг.
- Бусад төрийн байгууллагуудын хувьд цахим өгөгдлийн шинжилгээ хийж үр дүнд хүрсэн туршлага бага.
- + ҮСХ хувь хүний нууцын мэдээллийг хамгаалдаг, дотоод хэрэглээнд нэргүй болгодог бөгөөд нэргүй болгосон өгөгдлөө нээлттэй өгөгдөл болгон гаргадаггүй.

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Мэдээллийн менежмент	Өндөр	ШАР	Төрийн ихэнх байгууллагууд мэдээллийн системд машин унших форматаар өндөр ач холбогдолтой их хэмжээний өгөгдлийг хадгалж боловсруулдаг менежменттэй байна.
Өгөгдлийн мэдээлэл	Дунд	УЛААН	Мета-өгөгдөл, өгөгдлийн бүртгэл, баримтжуулалтын тухай ойлголт хангалтгүй.
Өгөгдлийн хэлбэр, байрлал	Өндөр	НОГООН	ҮДТ, нэг газар ихэнх төрийн байгууллагын өгөгдөл хадгалагдаж байгаа. Сайн бүтэцлэгдсэн өгөгдлийн сангийн форматаар хадгалагдаж байгаа. ХУР систем нэвтэрч байгаа.
Өгөгдлийн эрэлт	Өндөр	ШАР	Өгөгдлийн эрэлт байгаа боловч өгөгдөл солилцоход удаашралтай зохицуулалт байна.
Өгөгдлийн нээлттэй байдал	Өндөр	ШАР	Өгөгдлийг нээлттэй татаж авч байгааг бусдад үлгэрлэсэн жишээ цөөн бий. Өгөгдөл ашиглах нөхцөл шаардлага нь тодорхойгүй.
Өгөгдөл нэргүйжүүлэлт	Өндөр	УЛААН	ҮСХ-оос бусад төрийн бусад байгууллагуудад болон нэгдсэн нэргүй болгох аргачлал бодлого байхгүй байна.
Манлайлагч байгууллага	Өндөр	НОГООН	ҮСХ өгөгдлийн удирдлагын чадавхыг сайн нэвтрүүлсэн байна.
<b>НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ</b>		<b>ШАР</b>	<b>Өгөгдлийн удирдлагын чадавхтай, манлайлагч байгууллагын туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэх шаардлагатай.</b>

## 5 НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЭРЭЛТ

**Ач холбогдол:** Маш өндөр

**Агуулга:** Өгөгдлийн үнэ цэнэ нь түүнийг хэрэглэхэд оршдог. Өгөгдлийн эрэлт их байх нь төрөөс өгөгдөл үүсгэх, арчлах, нийтэд нээлттэй болгохыг шаарддаг. Үүнээс гадна Нээлттэй өгөгдлийн экосистемийг өргөжүүлж хөгжүүлэх; нийгэм, эдийн засгийн хувьд үнэ цэнэтэй үйлчилгээг иргэдэд хүрэхэд чухал байдаг. Эрэлтийг бий болгож байгаа гол хүч нь иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагчид болон иргэд болно.

### 5.1 Иргэний нийгмийн байгууллагууд, Хөгжлийн түншүүд, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын өгөгдлийн бодит болон далд эрэлтийн түвшин ямар байна вэ? (Ач холбогдол: Өндөр)

- + Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга<sup>25</sup>, Нээлттэй нийгэм хүрээлэн, Ил тод байдал сан зэрэг иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй өгөгдлийн манлайлагчид бөгөөд тэд төрийн зарим өгөгдлийг цуглуулж нээлттэй өгөгдөл болгож түгээдэг бол зарим нь төрийн нээлттэй өгөгдлийг боловсруулж мэдээлэл болгон нийгэмд түгээдэг.
- + Нээлттэй нийгэм хүрээлэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Ил тод сан, “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ<sup>26</sup>, “Төлсөн авснаа нийтэл” эвсэл<sup>27</sup> зэрэг эдгээр ТББ-ууд нь төрийн төсвийн болон уул уурхайн мэдээллийг системтэй байдлаар авч өөрийн үндсэн үйл ажиллагаандаа ашигладаг.
- o Хөгжлийн түнш байгууллагууд төрийн өгөгдлийг хамтын ажиллагааны хүрээнд авч ашигладаг хэдий ч тэдний ашиглаж байгаа өгөгдлүүд нээлттэй байдлаар байдаггүй.
- + Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж олон нийт төсвийн зарцуулалтыг хянах боломжтой болсон.

<sup>25</sup> Resource contracts, <http://resourcecontracts.org/search?q=mongolia>, хандсан: 2018-04-13

<sup>26</sup> Иргэд төсвөө хянана, <http://www.tusuv.mn>, хандсан: 2018-04-13

<sup>27</sup> Төлсөн авснаа нийтэл, <https://tanevsel.wordpress.com>, хандсан: 2018-04-13



Үүнийг дагаад төсвийн болон зарцуулалтын нийгмийн бүртгэл, хяналтыг хийдэг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ, “Төлсөн авснаа нийтэл” эвсэл, Ил тод байдал сан, Төсвийн мэргэжилтнүүдийн холбоо, Нээлттэй нийгэм хүрээлэн зэрэг ТББ-ууд, хөдөлгөөн бий болсон.

- + Иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагад хүсэлт гаргаж өгөгдөл болон баримтын мэдээлэл авдаг.
- Өгөгдөл авах хууль эрх зүйн тодорхой орчин бүрдсэн ч өгч буй өгөгдөл, мэдээлэл хүссэн хэмжээнд байж чаддаггүй. Учир нь төрийн байгууллага үүргээ сайн ухамсарладаг хэдий ч төрийн албан хаагчийн өгөгдлийн мэдлэг, чадавх дутдаг гэж иргэний нийгмийн байгууллагууд үздэг.
- + МИДАС ТББ хэвлэл мэдээллийн байгууллагуудад зориулж өгөгдөл боловсруулах сургалт хийж байсан. Сүүлийн үед эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэхээс илүү нээлттэй өгөгдөлд тулгуурлан дүгнэлт, шинжилгээ хийх хандлага бий болсон. Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг болон бусад нээлттэй өгөгдлийг боловсруулж сонирхолтойгоор дүрслэн хүргэдэг ikon.mn цахим сонины туршлага байгаа.
- Өгөгдөл сурвалжит сэтгүүл зүйн арга техник ашигладаг байгууллага маш цөөн. Мэдээллийн технологи, өгөгдлийг боловсруулах чадавх сэтгүүл зүйн байгууллагад сул байна.
- o Нээлттэй нийгэм форум, Ил тод байдал сан зэрэг иргэний нийгмийн байгууллага вэб сайт хөгжүүлэх болон удирдан зохион байгуулах тодорхой туршлагатай.
- Програмын хангамж, шинэлэг вэб сайт хөгжүүлж удирдах чадамж иргэний нийгмийн байгууллагын дунд сул байна. Өгөгдлийг боловсруулахдаа хүснэгтэн өгөгдөлтэй ажилладаг уламжлалт програмыг ашигладаг.

## **5.2 Бизнес/хувийн хэвшлийн түвшинд өгөгдлийн бодит болон далд эрэлтийн түвшин ямар байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- Төрийн өгөгдлийг бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж үр ашигтай ажилладаг хувийн хэвшлийн байгууллага маш цөөхөн байдаг.

- Төрийн өгөгдлийг авч ашиглаад үр ашигтай ажиллах сонирхолтой аж ахуйн нэгжүүд байна. Гэвч тэдний үйл ажиллагаандаа ашиглах боломжтой өгөгдөл нээлттэй байдаггүй.
- Төрийн байгууллагаас газрын зураг худалдан авдаг бизнесийн байгууллагууд байдаг<sup>28</sup>. Гэхдээ ихэнх газрын зураг ашиглаж байгаа байгууллагууд орон зайн мэдээллийн бусад нээлттэй сан болох OpenStreetMap, Google Maps зэргийг ашиглахыг илүүд үздэг. Хувийн хэвшлүүдэд илүү дэлгэрэнгүй газар зохион байгуулалт, найдвартай эх сурвалжит чанартай өгөгдөл хэрэгтэй байдаг.
- + Газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагууд ЦУОШГ<sup>29</sup> боловсруулж гаргадаг төрөл бүрийн ус, цаг уур, орчны өгөгдөл авч ашигладаг.
- Тээврийн өгөгдөл ашиглаж байгаа бизнес/хувийн хэвшлийн байгууллагууд байхгүй. Техникийн хяналтын түүх, зорчигч тээврийн чиглэл, явсан замын бодит хугацааны өгөгдлийг нээлттэй болговол авч ашиглах бизнес/хувийн хэвшлийн байгууллагууд бий.
- Бизнес-бизнес зарчимд суурилсан хөрөнгө оруулалт, зах зээлийн судалгаа хийдэг байгууллагууд байдаг бөгөөд тэд статистик мэдээллийг ихэвчлэн ашигладаг.

### **5.3 Өгөгдлийн эрэлтийг төрийн байгууллагууд хэрхэн хүлээн авч мөн хариу арга хэмжээ авч байна вэ? (Ач холбогдол: Дунд)**

- Төрийн бүх шатны байгууллагуудад төрөөс хүсэж байгаа болон авч байгаа өгөгдлийн эрэлтийг тодорхойлсон судалгаа байхгүй. Эрэлтийг тодорхойлоход ашиглаж болохуйц бүртгэл (бүх төрлийн албан бичгийн бүртгэл, хөтлөлт, хяналтын програм г.м) тодорхой хэмжээнд байдаг боловч үүнийг ашиглан өгөгдлийн эрэлтийг тодорхойлох, нийлүүлэх талаар ажил

<sup>28</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, <http://www.gazar.gov.mn>, хандсан: 2018-4-16

<sup>29</sup> Цаг уур, орчны мэдээллийн үйлчилгээ, <http://tsag-agaar.gov.mn/>, хандсан: 2018-05-15

хийдэггүй.

- Төрийн байгууллагуудаас мэдээлэл авах эрх чөлөөний хуулийн дагуу судлаачид болон ТББ-ууд мэдээлэл авдаг боловч дэлгэрэнгүй эрэлтийн судалгаа байхгүй.
- + Шилэн дансны тухай хуулийн дагуу ил тод байдлыг хангах, хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцөлийг бий болгож иргэд, олон нийтэд мэдээлж байгаа нь төрөөс төсвийн орлого зарлагын мэдээллийг авах эрэлтийг хангаж байгаа нэг хэлбэр болно<sup>30</sup>.
- + Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар иргэн төрийн бүх байгууллагаас хүсэлт гаргаж мэдээлэл авах боломжтой.
- “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийн талаарх судалгаа байхгүй.
- + ҮСХ нь УИХ-ын харьяа байгууллага бөгөөд тэргүүлэх чиглэлийг Статистикийн тухай хуулиар зааж өгсөн байдаг. Мөн НҮБ-аас гаргадаг олон улсын статистикийн чиглэлийг ҮСХ үйл ажиллагаандаа тусгадаг. Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй холбоотойгоор чиглэлүүдийг мөн гаргадаг. Үүний нотолгоо нь статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр<sup>31</sup> болно.
- + Орон зайн өгөгдлийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хариуцдаг. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030<sup>32</sup> хөтөлбөрт үндэсний орон зайн дэд бүтцийг бий болгоно гэж тусгасан байдаг. Орон зайн өгөгдлийг хөгжүүлэх чиглэлийг хөгжлийн хөтөлбөр болгонд тусгаж явдаг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг<sup>33</sup>

<sup>30</sup> Шилэн данс, <https://shilendans.gov.mn>, хандсан: 2018-03-13

<sup>31</sup> Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, <https://www.nso.mn/page/153>, хандсан: 2018-03-25

<sup>32</sup> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, <http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2015/06/монгол-улсын-тогтвортой-хөгжлийн-үзэл-баримтлал-2030.pdf>, хандсан: 2018-04-24

<sup>33</sup> Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, [http://www.gazar.gov.mn/upload/news\\_files/5-201711161641719.pdf](http://www.gazar.gov.mn/upload/news_files/5-201711161641719.pdf), хандсан: 2018-07-10

боловсруулж байгаа болно.

**5.4 Төрийн байгууллагууд өгөгдлийн эрэлтийг хангах чиглэлээр хэрхэн ажиллаж буй талаар гаднын оролцогч талуудын байр суурь ямар байна вэ? (Ач холбогдол: Дунд)**

- Гаднын болон дотоодын оролцогч талуудаас төрийн бус өгөгдлийг эрэлтийг тодорхойлсон болон түүнийг хангах үйл ажиллагааны талаарх тодорхой байр суурь илэрхийлээгүй байна.
- + Гаднын оролцогч тал, гадаадаас санхүүждэг төрийн бус байгууллагуудын үзэж байгаагаар төр мэдээлэл авах хүсэлтийн хариуд төрийн байгууллагууд харьцангуй сайн хариу өгдөг боловч чанартай өгөгдөл өгөх тал дээр хангалтгүй байна.
- Тогтмол хүсдэг өгөгдлийг төрийн байгууллагууд нээлттэй болгож нийтлэх төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй.
- + Статистик, орон зайн лавлагаа мэдээлэл зэрэг гол өгөгдлийн сангийн дэд бүтцийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход гаднын оролцогч тал болох НҮБ болон бусад байгууллагууд маш сайн анхаарч хамтран ажилладаг.

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Иргэдийн талаас өгөгдлийн эрэлт	Өндөр	ШАР	Иргэн, ТББ, сэтгүүлчид зэрэг өгөгдлийн эрэлт үүсгэгч талууд бага байна.
Бизнес талаас өгөгдлийн эрэлт	Өндөр	УЛААН	Бизнесийн байгууллагаас өгөгдлийн эрэлт бага байна.
Эрэлтийг хүлээн авах байдал	Дунд	УЛААН	Төрд өгөгдлийн ил болон далд эрэлтийн судалгаа байхгүй.
Оролцогч талуудын санал бодол	Дунд	УЛААН	Өгөгдлийн хүсэлтэд хариу өгдөг боловч өгөгдлийн чанарын асуудал, эрэлт ихтэй өгөгдлийг нийтлэх төлөвлөгөөгүй байна.
<b>НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ</b>		<b>УЛААН</b>	<b>Төрийн байгууллагууд өгөгдлийн бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж өгөгдлийн эрэлтийг тодорхойлж, нийлүүлэлтийг оновчтой хангаж ажиллах шаардлагатай.</b>

## 6 ИРГЭДИЙН ОРОЛЦОО, НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН БОЛОМЖ

**Ач холбогдол:** Өндөр

**Агуулга:** Нээлттэй өгөгдлийг манлайлагч засгийн газруудын туршлагаас харахад Нээлттэй өгөгдлийн санаачилга нь засгийн газар өгөгдлийг зөвхөн нийлүүлэхээс гадна бодлого/хууль эрх зүйн орчин, байгууллагын тогтолцооны бэлэн байдал, чадавхыг хөгжүүлэх (төр болон мэдээллийн зуучлагчдын), иргэдийн оролцоо, инновацийн санхүүжилт болон технологийн дэд бүтэц зэрэг асуудлыг авч үздэг. Нээлттэй өгөгдлийн “экосистем” аргыг хэрэглэх үед илүү тогтвортой, үр нөлөөтэй байдаг. Засгийн газар Нээлттэй өгөгдлийн экосистемд олон талт үүрэг хүлээх, оролцогч талуудтай өргөн хүрээнд түншлэлийн шинэ хэлбэр үүсгэх хэрэгтэй байдаг.

### 6.1 Нээлттэй өгөгдлийг олон нийтэд зориулан хөрвүүлж ойлгомжтойгоор мэдээлэх мэдээллийн ямар зуучлагчид (өгөгдлийн сэтгүүлчид гэх мэт) байна вэ? Нээлттэй өгөгдлийн экосистемийн энэ хэсгийг хөгжүүлэх болон сайжруулахад ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай вэ? (Ач холбогдол: Өндөр)

- + Төрийн нээлттэй өгөгдлийг боловсруулж энгийн болон интерактив байдлаар дүрслэх, хүснэгтэлж хүргэдэг хэвлэл мэдээлэл, ТББ-ууд байдаг. Тухайлбал, Монгол ТВ, ikon.mn, gogo.mn, Bloomberg TV, Нээлттэй нийгэм хүрээлэн болон Ил тод байдлын сан зэрэг болно.
- Монголын сэтгүүлзүй ихэвчлэн томоохон хэвлэл мэдээллийн байгууллага тойрсон зохион байгуулалттай байдаг. Нийгмийн сүлжээ, мэдээллийн технологийн хөгжлийн давуу талыг ашигласан чөлөөт/хараат бус сэтгүүлчид цөөн боловч оршин байна.
- + Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн 72% нь хувийн хэвшлийнх байна. Харин телевизүүдийн 10%, сонин хэвлэлийн 8%, сэтгүүлийн 13%, радиогийн 12%-ийг төр эзэмшдэг<sup>34</sup> бол үндэсний хэмжээний олон нийтийн статус

<sup>34</sup> Монголын хэвлэл мэдээллийн зах зээл, Media ownership monitor Mongolia, <http://mongolia.mom-rsf.org/mn/translation-context/translation-media-market/>, хандсан: 2018-04-20

бүхий, Олон нийтийн радио, телевизийн тухай<sup>35</sup> хуулиар зохицуулагддаг ганц Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ) байдаг байна.

- + Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нэртэй хараат бус сэтгүүлзүйн нийгэмлэг байдаг.

## **6.2 Төрийн эзэмшлийн өгөгдлийг дахин ашиглахыг дэмжиж сурталчилсан ямар үйл ажиллагаанд төр оролцож байна вэ (програм хангамж хөгжүүлэх эсвэл хамтран арга хэмжээг зохион байгуулах гэх мэт)? Ийм дэмжлэгийг хэрхэн хөгжүүлж, мөн сайжруулж байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- Сүүлийн үед програм хангамж (вэб, гар утасны апп) хөгжүүлэхэд Засгийн газар/агентлагийн өөрсдийн оролцоо их болж байна. Энэ нь төр хувийн хэвшилтэй өрсөлдөх үзэгдэл болж байгаа бөгөөд хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаанд сөрөг нөлөөтэй.
- + Жил бүр Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн чуулганыг МХХТГ болон Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран зохион байгуулдаг.
- o МТҮП, Старт-ап Монголиа, МУИС зэрэг байгууллагууд хэд хэдэн хакатон тэмцээн зохион байгуулсан байдаг. Гэвч эдгээр тэмцээнд төрийн байгууллагын оролцоо байгаагүй.
- + Нээлттэй нийгэм хүрээлэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Ил тод байдал сан зэрэг ТББ-ууд төрийн өгөгдлийг тогтмол хэрэглэдэг.

## **6.3 Сошиал медиа болон бусад тоон сувгаар төртэй хамтран ажиллах ажлын цар хүрээ ямар байна вэ? (Ач холбогдол: Дунд)**

- + Иргэдийн сошиал медиа ашиглалт нь маш өндөр байдаг. Фэйсбүүк компаниас гаргасан The Inclusive Internet Index 2018 жагсаалтад Монгол улс

<sup>35</sup> Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/424>, хандсан: 2018-07-24

Affordability<sup>36</sup> үзүүлэлтээр Азид 1, дэлхийн 10 дугаар байрт орсон байдаг. Хамгийн өндөр хэрэглээтэй нийгмийн сүлжээний платформ Facebook, Twitter, Instagram байна.

- Төрийн байгууллагууд нийгмийн сүлжээ, бусад цахим хэрэгслээр үйл ажиллагаагаа ихэвчлэн сурталчилдаг. Нийгмийн сүлжээг сонсох, иргэдтэй цахим хэлбэрээр холбогдох талаар баримталдаг нэгдсэн бодлого байхгүй.
- + Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээх авах Засгийн газрын 11-11 төв<sup>37</sup>, УИХ-ийн тамгын газрын Хуулийн цахим хэлэлцүүлэг<sup>38</sup>, Улаанбаатар хотын өргөдөл, санал гомдлын [ub1200.mn](http://ub1200.mn) зэрэг вэб сайт байдаг. Мөн төрийн байгууллагуудын цахим хуудсаар дамжин санал, хүсэлт өгөх боломжтой. Гэвч үйл ажиллагаа суларсан, хамрах хүрээ бага байна.
- Иргэдийн цахим оролцоог эрчимжүүлэхийн тулд иргэдийн санал хүсэлтийг нэгтгэж хэрхэн хэрэгжүүлсэн, авсан арга хэмжээ, үр дүн, ач холбогдлын талаар эргэн тайлагнах тогтолцоо сул байна.
- o Иргэдтэй цахимаар холбогдох, оролцоог бий болгохын тулд радио, телевизийн өргөн нэвтрүүлгээр сурталчилдаг.
- + Олон нийтийг хамарсан улс төрийн болон нийгмийн асуудалд иргэд нийгмийн сүлжээгээр холбогдож дуу хоолойгоо хүргэж байна.
- Олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг өгөгдөлд тулгуурлаж мэдээллээр хангах байдлаар явагддаггүй.
- Төрийн ихэнх өгөгдөл нийтэд нээлттэй биш, хайж олж авахад хүндрэлтэй байдаг тул улс төр болон нийгмийн гол асуудалд иргэд хоорондоо өгөгдөлд тулгуурласан хэлэлцүүлэг хийх боломж хомс байна.

---

<sup>36</sup> The Inclusive Internet Index 2018, <https://theinclusiveinternet.eiu.com/explore/countries/performance?category=affordability>, хандсан: 2018-03-21

<sup>37</sup> Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв, <https://11-11.mn>, хандсан: 2018-03-09

<sup>38</sup> Хуулийн нээлттэй форум, [/www.forum.parliament.mn/](http://www.forum.parliament.mn/), хандсан: 2018-02-23



#### **6.4 Апп эдийн засгийн<sup>39</sup> цар хүрээ хэр вэ? (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- + Тогтсон соёлтой болсон. Тухайлбал, банкны аппликэйшн хамгийн түгээмэл ашиглагдаж бөгөөд төрийн зарим нийтлэг үйлчилгээг гар утасны аппликэйшнээр авах боломжтой болсон.
- Төрийн нээлттэй өгөгдөл дээр суурилсан апп одоогоор байхгүй.
- Монгол улсад хувийн хэвшил төрийн өгөгдөл ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа туршлага байхгүй байна.

#### **6.5 Өгөгдлийн дүн шинжилгээ хийх чадавх, техникийн ур чадвар бүхий хүмүүсийг сургадаг академи болон эрдэм шинжилгээний байгууллага ямар түвшинд байна вэ? (Ач холбогдол: Дунд)**

- + Програм хангамж, компьютерийн ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг ууган сургуулиуд болох Монгол улсын их сургуулийн (МУИС) Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн (ШУТИС) Мэдээлэл, холбооны технологийн сургуулиуд энэ чиглэлээр бакалавр, магистр, докторын хөтөлбөртэй. Мөн бусад хувийн хэвшлийн сургуулиудад бий.
- + 2017-2018 оны компьютерийн ухааны мэргэжлээр төгсөгчдийн тоо<sup>40</sup> нийт 711 байна.
- + МУИС бакалавр болон ахисан түвшний статистик хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг.
- + МУИС, ШУТИС нь вэб/компьютерийн ухааны чиглэлээр засгийн газрын ХХМТГ, ХХЗХ, НМТГ зэрэг салбарын байгууллагатай холбоотой ажилладаг.
- + Монголын мэдээллийн технологийн консорциум 2013 оноос энэ салбарын судалгааны байгууллагуудыг холбож ажиллаж байна.
- + МУИС, ШУТИС-д өгөгдлийн шинжилгээ, их ба нээлттэй өгөгдлийн чиглэлээр

<sup>39</sup> Гар утасны аппликэйшныг тойрсон эдийн засгийн үйл ажиллагаа

<sup>40</sup> Дээд боловсролын салбарын 2017-2018 статистик, <https://mecss.gov.mn/news/728/>, хандсан: 2018-06-05

судалгаа хийдэг.

- + Дунд сургуулийн хөтөлбөрт МХТ-ийн хичээлүүд байдаг.
- + Бүх нийтийн компьютерийн хэрэглээг сайжруулах, бие даан суралцахад зориулж 2015 онд ХХМТГ-аас сурах бичиг<sup>41</sup> нийтлүүлсэн байдаг. Үүнийг ашиглан дунд сургуулийн багш нарыг бэлтгэж, сургаж байсан.
- + МУИС, ШУТИС-ийн програм хангамж, мэдээллийн технологийн хөтөлбөрүүдэд вэб инженерчлэл, семантик вэб, их өгөгдлийн технологийн тухай авч үздэг. Мөн өгөгдлийн сангийн удирдлага, өгөгдөлтэй ажиллах технологийг үздэг.

---

<sup>41</sup> Компьютерийн хэрэглээ, <http://www.ict.edu.mn/uploaded/book/TextBook1.pdf>, хандсан: 2018-06-13

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Боломжит мэдээллийн зуучлагчид	Өндөр	ШАР	Монголын хэвлэл мэдээллийн байгууллагын бүтэц хувийн хэвшил түлхүү байгаа боловч нөлөөлөлд өртөх боломжтой томоохон байгууллагуудыг тойрсон байна. Чөлөөт сэтгүүлчдийн орон зай бага байна.
Өгөгдөл дахин ашиглалт	Өндөр	УЛААН	Төрийн өгөгдлийг дахин ашиглах талаар төрийн оролцоо бага, дэмжиж сурталчилсан үйл ажиллагаа явуулдаггүй.
Төрийн хамтын ажиллагаа	Дунд	ШАР	Төр иргэдтэй цахимаар холбогдох суваг бий боловч хэрэгжилт хангалтгүй байна.
Апп эдийн засаг	Дундаас өндөр	ШАР	Апп соёл харьцангуй бий болсон боловч нээлттэй өгөгдөл тулгуурласан апп байхгүй байна.
Академик хүрээ	Дунд	ШАР	Өгөгдлийн дүн шинжилгээ хийх чадавх, техникийн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэдэг академик байгууллагууд бий. Гэвч өгөгдлийн шинжилгээ, их өгөгдөл, семантик вэбийн чиглэлээр хамтарч ажилладаг туршлага, төгсөгчдийн тоо бага.
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		ШАР	Төрийн өгөгдлийг ашиглах оролцогч талуудтай цахим түвшинд сайтар ажиллаж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

## 7 НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

**Ач холбогдол:** Дундаас өндөр

**Агуулга:** Нээлттэй өгөгдлийн “эрэлт” болон “нийлүүлэлт” талын аль алиныг санхүүжүүлэх нь Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн зорилтуудыг хангаж баталгаажуулахад чухал ач холбогдолтой.

### 7.1 Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн эхний үе шатыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хэрхэн тодорхойлж болох вэ? Хэн ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ? (Ач холбогдол: Маш өндөр)

- + Ухаалаг засаг төсөл 2020 он хүртэл хэрэгжих хугацаанд Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг эхэн үед санхүүжүүлэх хамгийн боломжит сонголт байна.
- o Засгийн газар Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг цаашид улсын төсвөөс санхүүжүүлэх сонирхолтой байна.
- Үндэсний хэмжээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийг гадаад улсын байгууллагаар санхүүжүүлэх сонирхолгүй байдаг.
- + Дэлхийн банк хамгийн их сонирхлоо илэрхийлж Ухаалаг засаг төсөлд нээлттэй өгөгдлийн хөгжүүлэх ажлыг оруулж санхүүжилтийн зээл олгоод байна.
- o Монгол Улсын засгийн газарт нээлттэй өгөгдөл нь шинэ ойлголт учраас бизнесийн нөхцөлд өргөжүүлэх асуудал яригдаж байгаагүй тодорхойгүй байна.
- + Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Ерөнхий сайд, ЗГХЭГ дарга, Сангийн сайд нарт сайн ойлгуулж дэмжлэг авах шаардлагатай. Мөн УИХ-ийн Цахим бодлогын түр хороогоор дэмжүүлэх боломжтой.
- + Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас санхүүжүүлэх боломжтой.

**7.2 Нээлттэй өгөгдөл ашиглах ямар нэгэн гарааны апп болон цахим үйлчилгээг санхүүжүүлэх аливаа эх үүсвэр байна уу? Тэдгээрийг тодорхойлсон уу? (Ач холбогдол: Өндөр)**

- + Төрийн байгууллагын үйлчилгээг хүргэх гар утасны аппыг байгууллагын төсвөөс санхүүжүүлж хөгжүүлсэн туршлага бий. Нээлттэй өгөгдөлд түшиглэсэн эхний апп эдгээр санхүүжилтийг татах боломжтой байна.

**7.3 МХТ-ийн шаардлагатай дэд бүтцийг дэмжих, Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг удирдах ур чадвартай ажилтнуудыг бэлтгэхэд санхүүгийн боломжит эх үүсвэр юу байна вэ? (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- + Төрийн нэгдсэн сүлжээгээр мэдээлэл солилцдог ХУР системийг ашиглан нээлттэй байж болох өгөгдлийг нэгтгэж түгээх нийтлэг дэд бүтцийг нэвтрүүлэх боломжтой бөгөөд төсвийн хөрөнгөөр санхүүжиж байгаа.
- Төрийн ихэнх байгууллагад өгөгдлийн менежментийн асуудлыг тусгайлан хариуцдаг албан тушаалтан, ажилтан байхгүй байна.
- + ҮСХ хороонд өгөгдлийн менежмент хариуцсан мэргэжилтэнтэй.
- + Нээлттэй өгөгдлийн порталыг өгөгдлөөр хангах гол байгууллагууд мэдээллийн систем өргөн ашигладаг, мэдээллийн системийн ашиглалт, арчилгаа, зарим талаар хөгжүүлэлт хариуцдаг мэргэжлийн газар хэлтэс, нэгжтэй байдаг учир өгөгдлийг боловсруулж нийтлэх техникийн ур чадвартай.
- + Өгөгдөл нийтлэх гол байгууллагууд өөрсдийн төсвийн хөрөнгөөр нээлттэй өгөгдлийн порталыг өгөгдлөөр хангах асуудлыг шийдвэрлэх боломжтой.

**7.4 Инновацийг санхүүжүүлэх төрийн ямар механизм байдаг вэ? (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- Програм хангамж эсвэл цахим үйлчилгээг хөгжүүлэхэд зориулсан төрийн ямар нэг сан байхгүй байна.

- Монгол улсад Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан<sup>42</sup> байдаг. Мөн Засгийн газраа жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр 1999, 2005, 2014 онуудад баталж хэрэгжүүлсэн байдаг. Одоо 2018-2020<sup>43</sup> онд хэрэгжих хөтөлбөрийг боловсруулж байгаа. Гэвч програм хангамж, цахим үйлчилгээ хөгжүүлэх компаниудад хөнгөлөлттэй зээл олгох, дэмжих бодлого байдаггүй.
- + МТҮП энтрепренёр, гарааны компани, инкубаторын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, чиглүүлэх, олон улсад өрсөлдөх чадвар бүхий компани, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.
- + Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газраас #Hub инновацийн төвийг 2018 онд нээж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Нийслэлд инноваци, гарааны компанийг дэмжих хувийн хэвшлийн төвүүд хэд хэд бий.
- + Төрийн бус байгууллага, хувийн хэвшлүүд энтрепренёршип, гарааны бизнес, жижиг дунд үйлдвэрлэлийг сурталчлах, дэмжих чиглэлээр төртэй хамтарсан болон бие даасан үйл ажиллагаа явуулдаг туршлага байна.
- 2007-2015 онд Инновацийг дэмжих хөтөлбөр батлагдсан ч хэрэгжилт маш хангалтгүй байсан.
- Гаднын хандивлагч орнууд болон төрийн бус байгууллагуудаас өөрөөр иргэний нийгмийн байгууллагын чадавхыг хөгжүүлэх, төрийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн сан байхгүй байна.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого<sup>44</sup> 2009 онд батлагдсан. Технологийг үнэлдэг тогтолцоо байхгүй учир технологитой холбоотой төр хувийн хэвшлийн түншлэл асуудалтай хэвээр байна.

---

<sup>42</sup> Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх сан, <http://www.smefund.gov.mn/>, хандсан: 2018-07-21

<sup>43</sup> Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр 2018-2020 он, <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol23.pdf>, хандсан: 2018-04-15

<sup>44</sup> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, <http://www.legalinfo.mn/annex/details/3312?lawid=6653>, хандсан: 2018-04-03

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
Эхлэлийн санхүүжилтийн эх үүсвэр	Маш өндөр	ШАР	Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг төсвөөс санхүүжүүлэхэд улс төрийн манлайлал чухал. Ухаалаг засаг төслөөс нээлттэй өгөгдлийг тодорхой хэмжээнд дэмжиж байгаа. Гэвч урт хугацаанд хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.
Апп санхүүжилтийн эх үүсвэр	Өндөр	ШАР	Төрийн байгууллага өөрийн төсвөөс апп, цахим үйлчилгээг санхүүжүүлэх бүрэн боломжтой боловч тодорхойгүй.
МХТ дэд бүтэц, ур чадварын дээшлүүлэх санхүүжилтийн эх үүсвэр	Дундаас өндөр	ШАР	Нээлттэй өгөгдлийн порталыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, техникийн ур чадвартай ажилчдыг бэлтгэхэд шаардагдах санхүүжилтийг төсвөөс гаргадаг боловч хүрэлцээгүй.
Инновацийн санхүүжилтийн эх үүсвэр	Дундаас өндөр	УЛААН	Инновацийн сан татан буугдсан, төрөөс тогтмол найдвартай санхүүжүүлэх боломж хомс байна. Гарааны компанийг дэмжих төв, хувийн хэвшлээс санхүүжүүлж байгаа.
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		ШАР	Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд улс төрийн манлайлал чухал шаардлагатай. Мөн инновацийн сангууд хэрэгтэй.

## 8 ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ДЭД БҮТЭЦ, УР ЧАДВАР

**Ач холбогдол:** Өндөр

**Агуулга:** Ихэнх практикт, Нээлттэй өгөгдлийн хөтөлбөр нь тухайн орны харилцаа холбооны технологи болон төрийн албан хаагч, мэдээллийн зуучлагч, иргэдийн МХТ-ийг хэрэглэх чадамж, ур чадвар зэрэг харилцаа холбооны дэд бүтэц, мэдээллийн технологийн ололт амжилтад гол төлөв түшиглэсэн байдаг.

### 8.1 МХТ-ийн дотоодын "экосистем" ямар байна вэ? Ямар технологиуд иргэдийн хэдэн хувьд хүрсэн бэ? (Ач холбогдол: Өндөр)

- + Хүн амын 122.3%<sup>45</sup>-д үүрэн холбооны үйлчилгээ авч байгаа бөгөөд үүний 62.7% ухаалаг утастай байна.
- o Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2017 оны байдлаар 144,768<sup>44</sup> байна.
- o Суурин интернетийн хэрэглэгчийн тоо 2017 оны байдлаар 267,451<sup>44</sup> байна.
- o Төрийн бүх байгууллагууд цахим хуудастай байдаг бөгөөд үйл ажиллагааныхаа тухай мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэдэг. Иргэд мэдээ мэдээллийг авах, энтертайнмент зорилгоор интернет хөтчийг ихэвчлэн ашигладаг.
- + Ердийн интернет хөтчид түшиглэсэн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг. Тухайлбал, НӨАТУС-ийн систем иргэн, аж ахуйн нэгжийн 1.3 сая хэрэглэгчтэй бөгөөд үүнээс 217,000 мянга нь интернет хөтөч ашигладаг байна. Түүнээс гадна, төрийн худалдан авах ажиллагаанд цахимаар оролцох; нийгмийн даатгал, санхүү, татварын тайлан хүлээлгэн өгөх; тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах, татвар, торгууль төлөх, автобусны тасалбар худалдах авах; интернет банкны гүйлгээ хийх; өрхийн хэрэглээний зардлыг цахимаар төлөх гэх мэт олон үйлчилгээг иргэд ердийн вэб хөтчөөр авдаг.
- + Ухаалаг гар утасны технологид түшиглэсэн НӨАТУС-ын Андроид үйлдлийн

<sup>45</sup> Салбарын 2017 оны жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, <http://www.crc.gov.mn/k/35/23>, хандсан: 2018-04-13



системтэй 1 сая удаа татсан<sup>46</sup>, нийт тээврийн хэрэгслийн татварын 5% (40 мянга) нь 10 мянган удаа татагдсан 2017 оны 12 сард ашиглалтад орсон SmartCar аппаар төлөгдсөн байна.

- Хөдөлгөөнт банкны нийт хэрэглэгчийн тоо 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар 1,219,959<sup>47</sup> бөгөөд нийт хүн амын 38.4% байна.
- + Лавлах үйлчилгээ, цахим банкны зарим үйлчилгээнд богино мессежийг идэвхтэй ашиглаж байна. Мөн үүрэн холбооны оператор компаниудын үйлчилгээг богино мессеж ашиглан идэвхжүүлэх, авах боломжтой.
- Тоон хуваагдал их. Хөдөө орон нутагт интернет үнэтэй байдаг учир орон нутгийн хандалт муу, нийт интернетийн урсгалын ~90%-д Улаанбаатар хотоос ачаалал үзүүлж байна.

## **8.2 Интернет хандалтын түвшин болон зардал өргөн зурвасын болон хөдөлгөөнт интернетийн технологиор хэр байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + Монгол улсын бүх 330 суманд 3G, 4G/LTE хөдөлгөөнт интернет нэвтэрсэн, 298 суманд (90.3%) шилэн кабель орсон байна. Нийт хүн амын 91.6% нь интернетэд холбогдох боломжтой.
- + Хүн амын 91.6% нь интернет хэрэглэгч бөгөөд нийт өрхийн 42.6%<sup>48</sup> нь компьютертэй байна.
- + Хөдөлгөөнт интернет нийт хүн амын 95%-д 3G, 25%-д 4G/LTE сүлжээгээр нэвтэрсэн байна.
- + Улаанбаатар хотод өргөн зурвасын 3Mbps өндөр хурдны интернет дунжаар 15,000 төгрөгийн үнэтэй, энэ нь олон улсын түвшнээс доогуур байдаг бол

<sup>46</sup> НӨАТУС гар утасны апп, <https://play.google.com/store/apps/details?id=mn.mta.vatps>, хандсан: 2018-07-26

<sup>47</sup> Хөдөлгөөнт банкны тайлан 2018 оны 1-р улирал, <https://www.mongolbank.mn/documents/paymentsystems/2018Q1HB.pdf>, хандсан: 2018-04-20

<sup>48</sup> Мэдээллийн технологи, харилцаа холбооны мэдээлэл 2017, [http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white\\_paper\\_2017\\_mn.pdf](http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white_paper_2017_mn.pdf), хандсан: 2018-04-13

орон нутагт 21,500 харьцангуй өндөр үнэтэй байна. Эдгээр үнийг нэг өрхийн сарын дундаж орлоготой<sup>49</sup> харьцуулахад Улаанбаатар хотод 0.015%, орон нутагт 0.022% байна.

- + Гар утасны хэрэглээний дундаж зардал 18,000 төгрөг байдаг.
- + Монгол Улсын бүх сумд гар утасны GSM900/1900/2100, CDMA450MHz, WCDMA сүлжээнд хамрагдсан байна.
- + Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас (ОУЦХБ) гаргасан МХТ-ийн хөгжлийн индексээр<sup>50</sup> Монгол Улс 2016 онд 87, 2017 онд 91-р байрт тус тус орсон байна. Ази номхон далайн орнуудаас 11-р байрт байна.

### **8.3 Тооцоолох болон хадгалах дэд бүтэц хэр бэлэн байна вэ? (Ач холбогдол: Дундаас өндөр)**

- + Вэб хостингийн үйлчилгээ үзүүлдэг 20+ компаниуд байдгаас хамгийн том гурван компани болох ДатаКом, АйТүүлс, ҮДТ-ийн хамгийн хямд багцын үнэ дунджаар 9,130 төгрөгийн<sup>51</sup> үнэтэй, хүртээмж өндөр байна.
- + Монголын вэб хостингийн үйлчилгээ үзүүлэгч бүх компани виртуал серверийн үйлчилгээ давхар үзүүлж байна. Хувийн хэвшлээс АйТүүлс ХХК манлайлж байна.
- + Төрийн байгууллагууд гадаад улсын үүлэн тооцоолол ашиглахыг Засгийн газрын 159 дүгээр тогтоолоор хорьсон байдаг учир төрийн байгууллагууд үүлэн тооцооллын үйлчилгээг зөвхөн ҮДТ-өөс авдаг.

### **8.4 Мэдээлэл технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэгчдийн бүлэг, тоон технологи тайлагдсан байдал хэр хүчтэй байна вэ? (Ач холбогдол: Өндөр)**

- + Монгол улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нийт

<sup>49</sup> Нэг өрхийн сарын дундаж орлого, <https://www.nso.mn/content/1578#.W1qJedIzaUk>, хандсан: 2018-07-27

<sup>50</sup> Global ICT Development Index, <http://www.itu.int/net4/ITU-D/idi/2017/index.html>, хандсан: 2018-04-14

<sup>51</sup> ДатаКом, АйТүүлс, ҮДТ-ийн вэб хостингийн үйлчилгээний хамгийн хямд багцын үнийн дундаж

ажиллагсад 2016 оны байдлаар 18.1 мянга<sup>52</sup> хүрээд байгаа бөгөөд нийт ажиллагсдын 1.6%-ийг эзэлж байна.

- + Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2017 оны байдлаар 1,074.4 тэрбум төгрөг байна.
- + Мэдээлэл, харилцаа холбооны салбар нь 2017 оны байдлаар Монгол улсын ДНБ-ний 1.95%-ийг<sup>53</sup> эзэлж байна.
- + Төрийн бүх яамд, зарим агентлагийн түвшинд байгууллагын үйл ажиллагаа, хяналт, удирдлагын нэгдсэн системийн хөгжүүлэлт, засвар үйлчилгээг дотоодын ABLE компаниар аутсорсинг хийлгэн ажиллаж байна.
- + Дотоодын вэб хөгжүүлэлт/вэб дизайны хөгжил сайн байгаа. Гадаадын зах зээлд вэб дизайны бүтээгдэхүүн борлуулдаг цөөн тооны компани, хөгжүүлэгчид бий. Програм хангамж үйлдвэрлэгч компаниудын ихэнх нь вэб хөгжүүлэлт, вэб дизайны бизнес давхар эрхэлдэг.
- + Програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо<sup>54</sup>, Залуу програмистуудын холбоо зэрэг төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг.
- + МТҮП нь мэдээллийн технологийн чиглэлээр энтрепренёр, гарааны компани, инкубаторын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, чиглүүлэх, олон улсад өрсөлдөх чадвар бүхий компани, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.
- o Нийслэлийн #hub инновацийн төв, Startup Mongolia, Startup Terminal Mongolia зэрэг инкубатор/хурдасгуур байгууллагуудын үйл ажиллагаа дөнгөж эхлэлийн шатанд байна.
- Венч сан болон гарааны хөрөнгө оруулалтын сан одоогоор хөгжөөгүй.
- Төрийн байгууллагын албан хаагчид болон иргэдийн дунд интернет хэрэглэх

<sup>52</sup> Мэдээллийн технологи, харилцаа холбооны мэдээлэл 2017, [http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white\\_paper\\_2017\\_mn.pdf](http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white_paper_2017_mn.pdf), хандсан: 2018-04-13

<sup>53</sup> Дотоодын нийт бүтэгдэхүүний статистик, [http://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L05&type=tables](http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L05&type=tables), хандсан: 2018-04-14

<sup>54</sup> Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо, [mosa.mn](http://mosa.mn), хандсан: 2018-06-11

ур чадварын түвшнийг үнэлсэн судалгаа байхгүй.

- + Нийгмийн сүлжээ ашиглах ур чадвар өндөр байдаг.
- o Төрийн бус байгууллагуудын өгөгдлийн ур чадвар ерөнхий түвшинд тодорхойлсон судалгаа байхгүй байна.
- + Монгол улсын хүн амын бичиг үсэг тайлагдсан байдал 98%-тай байгаа нь дэлхийн дунджаас өндөр үзүүлэлт юм.

Үнэлгээ:

АСУУЛТ	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
МХТ нэвтрэлт	Өндөр	ШАР	Өндөр хурдны интернетийн нэвтрэлт 25%, үүрэн холбооны хэрэглэгчийн тоо маш өндөр. Тоон хуваагдал их, орон нутагт интернетийн зардал өндөр байна.
Интернет үйлчилгээний түвшин	Өндөр	НОГООН	Интернет хандалтын түвшин өндөр. Хөдөлгөөнт интернетээс ихэнх хэрэглээ үүсэж байна. Интернетэд хандах зардал олон улсын дунджаас бага байдаг.
Тооцоолох, хадгалах дэд бүтэц	Дундаас өндөр	НОГООН	Төрийн байгууллагууд ҮДТ-ийн дэд бүтцээр дамжуулж мэдээлэл солилцох нэгдсэн системийг ашиглаж эхлээд байна.
Цахим хэрэглээний боловсрол	Өндөр	ШАР	Цахим бичиг үсэг тайлагдсан байдал тодорхой биш боловч цахим хэрэглээ сайн байгаа болно. Төрөөс үйлчилгээ гаргаж чадвал ашиглах чадамж сайн. Мэдээлэл технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэгчдийн бүлэг жижиг байна.
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		ШАР	Өндөр хурдны интернетийн нэвтрэлт хангалттай биш, тоон хуваагдал өндөр, МТ хөгжүүлэгчдийн бүлэг жижиг байна.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НӨББҮ-ий найман хэмжүүр бүрийн үнэлгээний тоймыг дараах хүснэгтэд үзүүлэв.

ХЭМЖҮҮР	АЧ ХОЛБОГДОЛ	ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ	ТАЙЛБАР
1. Удирдлагын манлайлал	Маш өндөр	ШАР	Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд гол хүчин зүйл болох улс төрийн/удирдлагын бодитой манлайллыг бий болгох хэрэгтэй.
2. Бодлого, эрх зүйн орчин	Өндөр	ШАР	Нээлттэй өгөгдлийг үүсгэхэд хуулийн талаас тулгарах саад, бэрхшээлгүй боловч нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөл, зөвшөөрөл тодорхой болгох шаардлагатай.
3. Байгууллагын бүтэц, төрийн хариуцлага, чадамж	Өндөр	ШАР	Өгөгдлийн менежмент болон МХТ-ийн ур чадварыг сайжруулахад анхаарч гүйцэтгэлийг үнэлэх шаардлагатай байна.
4. Төрийн өгөгдлийн менежмент, өгөгдлийн бэлэн байдал	Өндөр	ШАР	Өгөгдлийн удирдлагын чадавхтай, манлайлагч байгууллагын туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэх шаардлагатай.
5. Нээлттэй өгөгдлийн эрэлт	Маш өндөр	УЛААН	Төрийн байгууллагууд өгөгдлийн бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж өгөгдлийн эрэлтийг тодорхойлж, нийлүүлэлтийг оновчтой хангаж ажиллах шаардлагатай.
6. Иргэдийн оролцоо, нээлттэй өгөгдлийн боломж	Өндөр	ШАР	Төрийн өгөгдлийг ашиглах оролцогч талуудтай цахим түвшинд сайтар ажиллаж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.
7. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилт	Дундаас өндөр	ШАР	Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд улс төрийн манлайлал чухал

			шаардлагатай. Мөн инновацийн сангууд хэрэгтэй.
8. Технологийн үндэсний дэд бүтэц, ур чадвар	Өндөр	ШАР	Өндөр хурдны интернетийн нэвтрэлт хангалттай биш, тоон хуваагдал өндөр, МТ хөгжүүлэгчдийн бүлэг жижиг байна.

Монгол Улсад Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

### Удирдлагын манлайлал

ҮСХ, ТӨБЗГ байгууллагын засаглал, манлайллын хүрээнд нээлттэй өгөгдлийг амжилттай хөгжүүлж эхэлсэн, мөн ЗГ-ын 2020 хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийн бодлого боловсруулах, нээлттэй өгөгдөлд суурилсан хэрэглээг нэмэгдүүлэхээр тусгасан байгаа нь нээлттэй өгөгдлийг хөгжүүлж эхлэх боломж нөхцөл бүрдсэн гэж дүгнэж байна. Гэвч нээлттэй өгөгдлийг үндэсний хэмжээнд хөгжүүлэхийн тулд Нээлттэй өгөгдлийн хөтөлбөр боловсруулж улс төрийн/удирдлагын бодит манлайллаар удирдан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд нээлттэй өгөгдлийн ажлын хэсгийг байгуулж ажлын хэсгийн даргаар улс төрийн болон засгийн газрын томоохон албан тушаалтныг сонгож, нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан Засгийн газраар батлуулан хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Мөн Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагаатай уялдуулж ажиллах нь зүйтэй.

### Бодлого эрх зүйн орчин

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай болон Шилэн дансны тухай хуулиар иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж байгаа нь нээлттэй өгөгдөлд бодитой дэмжлэг болж байна. Харин хувь хүний нууцыг цахим орчинд хамгаалах, ашиглах харилцааг зохицуулсан өгөгдөл хамгаалах хууль болон өгөгдлийн эзэмшлийн бодлого, зохицуулалт, өгөгдлийг дахин хэрэглэхэд шаардлагатай лицензийг бусад дотоодын хууль тогтоомжид тусгах зайлшгүй шаардлагатай байна. Мөн одоо мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтуудад мэргэжлийн

зөвлөх багаар дүгнэлт хийлгэж шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг тусгах хэрэгтэй.

### **Байгууллагын бүтэц, төрийн хариуцлага, чадамж**

Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх чадвартай дунд шатны байгууллага цөөн байгаа болон нийтлэг дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд: Өгөгдлийн менежментийн процессыг төрийн бүх шатны байгууллагуудад нэвтрүүлэх, төрийн албан хаагчдын МХТ-ын ур чадварыг тогтмол дээшлүүлж, гүйцэтгэлийн үнэлгээнд тусгадаг байх, өгөгдлийг дахин ашиглах сонирхлын бүлэг болох хувийн хэвшил, ТББ, иргэд болон бусад төрийн байгууллагын оролцоог хангасан бүтэц, зохион байгуулалттай байх хэрэгтэй. Мөн нээлттэй өгөгдлийн талаар төрийн бүх шатны байгууллагын удирдах болон албан хаагчдад жилд нэг удаа танилцуулга, сургалт зохион байгуулж байх хэрэгтэй.

### **Төрийн өгөгдлийн менежмент, өгөгдлийн бэлэн байдал**

Төрийн байгууллагууд өөрсдийн мэдээллийн системд өндөр ач холбогдолтой бүтэцлэгдсэн өгөгдлийг ҮДТ-д байршуулан хадгалж байна. Өгөгдлийг нэг дор төвлөрүүлсэн техникийн менежмент нэвтрүүлснээр нээлттэй өгөгдлийн порталд өгөгдлийг нийтлэх таатай орчин бүрдсэн байна. Гэвч нээлттэй өгөгдөлд холбогдох өгөгдлийн менежментийн бусад асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Тухайлбал, мета-өгөгдөл, өгөгдлийн бүртгэл, баримтжуулалт, өгөгдлийн эрэлтийг цахимаар хангах механизм, өгөгдөл ашиглах нөхцөл шаардлага, өгөгдлийг нэргүй болгож нийтлэх аргачлал, нээлттэй өгөгдлийн манлайлагчдыг тодорхойлж тэдэнд тал бүрийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

### **Нээлттэй өгөгдлийн эрэлт**

Өгөгдлийн эрэлт төрийн байгууллагаас өгөгдөл үүсгэх, арчлах, нийтэд нээлттэй болгох, өгөгдлийн бүрэн бүтэн, үнэн зөв байдал болон чанарын баталгаа гаргаж өгөхийг шаарддаг. Эрэлтийг бий болгодог гол хүч – иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон иргэдээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн өгөгдлийн эрэлтийг тодорхойлж түүний нийлүүлэлтийг оновчтой хангах механизм шаардлагатай. Үүнээс гадна оролцогч талуудын хамтын



ажиллагаа, өгөгдлийг дахин ашиглахыг дэмжсэн үйл ажиллагаа, нийгэмд чиглэсэн сурталчилгааг зохион байгуулах хэрэгтэй. Тухайлбал, хамгийн эрэлт өндөртэй өгөгдлийн бүрдлийг нээлттэй болгох, түүчээ төслийг санаачлан иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн оролцоог хангасан байдлаар амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн төрийн байгууллага бүр өөрийн өгөгдлийн эрэлтийн судалгааг тогтмол хийх шаардлагатай.

### **Иргэдийн оролцоо, нээлттэй өгөгдлийн боломж**

Монгол улсад нээлттэй өгөгдлийн экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох мэдээллийн зуучлагч, чөлөөт сэтгүүлчдийн орон зай бага, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн харилцах сувгийн тоо цөөн, өгөгдөл дахин ашиглах техникийн чадавхтай иргэдийн тоо хангалтгүй байна. Иймд засгийн газар нээлттэй өгөгдлийг тогтвортой, илүү үр нөлөөтэй хөгжүүлэхийн тулд иргэдийн оролцоог хангах зорилгоор харилцах цахим сувгийн тоог нэмэгдүүлэх, өгөгдлийг дахин ашиглах чадавхыг сайжруулахад чиглэсэн сургалтыг олон нийт болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад явуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагаа, бусад нээлттэй өгөгдлийн боломжийг таниулсан үйл ажиллагаануудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах шаардлагатай.

### **Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилт**

Хэдийгээр Ухаалаг засаг төсөлд нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх санхүүжилт байгаа боловч нээлттэй өгөгдлийн экосистемийг бүрдүүлэхэд хүрэлцээгүй, Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг урт хугацаанд санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхойлоогүй байна. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг төсвөөс болон хувийн хэвшлээс санхүүжүүлэх боломжийг судлах, гарааны компани, өгөгдөл түшиглэсэн бизнесийн дэмжих инновацийн санг байгуулахад улс төрийн манлайлал, төсвийн шийдвэрлэлт нэн шаардлагатай.

### **Технологийн үндэсний дэд бүтэц, ур чадвар**

Улаанбаатар болон төвлөрсөн бүх хот, суурин өндөр хурдны интернетийн шугамд холбогдсон, хүн амын 122.3% нь үүрэн холбооны утас хэрэглэдэг, интернетийн болон үүрэн холбооны үйлчилгээний үнэ дэлхийн дунджаас хямд, төрийн захиргааны бүх байгууллагууд төрийн нэгдсэн сүлжээнд

холбогдож мэдээлэл солилцооны ХУР системээр өгөгдөл солилцож байгаа зэргээс үзэхэд хэрэглэгчийн болон төрийн байгууллагын дэд бүтцийн хүртээмж өндөр байгааг харуулж байна. Хэдийгээр интернетийн хэрэглээ өндөр, нийт хүн амын 91.6% нь интернетэд холбогдох боломжтой байгаа ч хөдөө орон нутгийн хувьд үйлчилгээний өртөг өндөр, хүртээмж муу, нийт төрийн албан хаагчдын болон бүх нийтийн цахим боловсрол хангалтгүй байна. Цаашид төрөөс орон нутгийн интернетийн хүртээмжийг сайжруулж, үнийг бууруулах бодлого хэрэгжүүлэх замаар бүх нийтийн цахим боловсролыг дэмжих нь зүйтэй.

## ХАВСРАЛТ

### А. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Архивлах	Бичлэг, баримт болон бусад түүхэн ач холбогдол бүхий материалыг (эсвэл тэдгээрийн цуглуулга) зэргийг тодорхой газар эсвэл агуулахад хадгалах
Өгөгдлийн менежмент	Өгөгдлийн үнэ цэнэ, мэдээллийн өгөөжийг нэмэгдүүлэх, түгээх, хамгаалах, хянахад чиглэсэн төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр болон бодит туршлагын удирдлага, гүйцэтгэл, хөгжүүлэлт
Мэдээлэл түгээгч	Олон нийт зэрэг өргөн хүрээнд өгөгдөл/мэдээллийг хялбархан ойлгох боломжийг олгож буй хувь хүн эсвэл байгууллага. Жишээ нь, хэвлэлийнхэн бол олон нийтэд мэдээллийг илүү ойлгомжтой байдлаар хүргэдэг гол мэдээлэл түгээгч юм.
Мета-өгөгдөл	Мета-өгөгдөл бол "өгөгдлийн тухай өгөгдөл" – өгөгдлийн бүрдлийн үндсэн төрх байдлыг тодорхойлдог. Жишээ нь, өгөгдлийн бүрдэл үүсгэхэд ямар байгууллага энэ өгөгдлийн бүрдлийг хариуцдаг, өгөгдлийн формат г.м.
Нээлттэй өгөгдөл	Хэн нэгэн "нээлттэй" лицензээр чөлөөтэй ашиглаж/өөр зориулалтаар хэрэглэж/дахин түгээж болдог машин унших форматтай өгөгдөл
Нээлттэй өгөгдлийн экосистем	Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх арга нь зөвхөн өгөгдөлд төвлөрөх бус нээлттэй өгөгдлийг хэрэглэх маш том хүрээнд төвлөрдөг – энэ бол "экосистем" – манлайлал, бодлого/хууль эрх зүй, байгууллага, тогтолцоо, хэрэглэгчдийн нийгэмлэгийн (жишээ нь, хөгжүүлэгчид, их сургуулиуд, хувийн хэвшил г.м) өнөөгийн байдал зэрэг бусад гол хэмжүүрүүдийг агуулдаг.
Нээлттэй өгөгдлийн портал	Засгийн газар, агентлаг, байгууллагаас нийтэлж буй нээлттэй өгөгдөлд нэг цэгээс хандах, хайх боломжийг олон нийтэд олгодог, каталогийн үйлчилгээ үзүүлдэг платформ (ихэвчлэн вэб сайтаар ханддаг)
Нээлттэй өгөгдлийн хөтөлбөр	Засгийн газар, агентлаг байгууллага эсвэл компаниас нийтэлж буй нээлттэй өгөгдлийг танилцуулах, удирдах чиглэсэн багц үйл ажиллагаа. Энэ үнэлгээ нь засгийн газар эсвэл хувийн хэвшлийн агентлагуудын хөгжүүлэх Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрт чиглэсэн болно.
Нээлттэй засаг	Засгийн газрыг хэрхэн илүү ил тод, хариуцлагатай, оролцоог дэмждэг (иргэдийн), хамтын ажилладаг болгох өөрчлөлтөд чиглэсэн философи эсвэл баримтлах зарчим.
Нээлттэй засгийн түншлэл	Засгийн газрыг илүү нээлттэй, хариуцлагатай, иргэдийн өмнө үүрэг хүлээдэг болгох орон нутгийн реформыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэлхийн нийтийн түншлэл. 2011 онд байгуулагдсан, одоогоор 60 гишүүн улстай.
Нээлттэй стандарт	Олон нийт ашиглах боломжтой, ашгийн бус, рояалти байхгүй техник стандарт. Нээлттэй стандартыг "нээлттэй" ил тод байдлаар, олон хүний оролцоотойгоор хөгжүүлдэг.

**Б. Уулзалт ярилцлагын жагсаалт**

№	Байгууллага	Огноо
<b>Төрийн байгууллагын бүтцийн бүх түвшинд өгөгдөл, мэдээллийн асуудал хариуцдаг байгууллага</b>		
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2018.03.19
2	Сангийн яам	
3	Хууль зүй, дотоод хэргийн яам	2018.03.20
4	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	
5	Архивын ерөнхий газар	2018.03.21
6	Үндэсний статистикийн хороо	
<b>Гол өгөгдлийн бүрдэл агуулагч байгууллага</b>		
7	Татварын ерөнхий газар	2018.03.28
8	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	
9	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	2018.03.29
10	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	
11	Үндэсний дата төв УТҮГ	2018.03.20
<b>Бусад өгөгдлийн бүрдэл эзэмшигч байгууллага</b>		
12	УИХ-ын тамгын газар	2018.03.22
13	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	
14	Эрүүл мэндийн яам	2018.03.23
15	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	
16	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	2018.03.26
17	Барилга, хот байгуулалтын яам	
18	Зам, тээврийн хөгжлийн яам	2018.03.27
19	Авто тээврийн үндэсний төв УТҮГ	
20	Авлигатай тэмцэх газар	2018.03.30
21	Санхүүгийн зохицуулах хороо	
22	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	2018.04.02
23	Стандарт, хэмжил зүйн газар	
24	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2018.04.03
25	Төрийн албаны зөвлөл	

Иргэний нийгмийн байгууллага болон өгөгдөл хэрэглэгч		
26	Мэдээллийн технологийн мэргэжилтэн бэлтгэдэг их сургуулийн төлөөлөл	2018.04.04
	<ol style="list-style-type: none"> <li>1. Монгол улсын их сургууль</li> <li>2. Шинжлэх ухаан технологийн их сургууль</li> </ol>	
27	Хувийн хэвшлийн төлөөлөл болон мэргэжлийн холбоод	2018.04.05
	<ol style="list-style-type: none"> <li>1. Интерактив ХХК</li> <li>2. АйТүүлс ХХК</li> <li>3. АстВижн ХХК</li> <li>4. Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ</li> <li>5. ККТТ ХХК (КүйПэй)</li> </ol>	
28	Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл	
	<ol style="list-style-type: none"> <li>1. Бенекрафт ХХК (ikon.mn)</li> <li>2. Ремо медиа ХХК</li> <li>3. Монгол ТВ</li> </ol>	
29	Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	2018.04.06
	<ol style="list-style-type: none"> <li>1. Төсвийн мэргэжилтнүүдийн холбоо ТББ</li> <li>2. Ил тод байдал сан ТББ</li> <li>3. Нээлттэй нийгэм хүрээлэн ТББ</li> <li>4. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн ТББ</li> </ol>	
30	Инноваци, инкубаторын төв	2018.04.09
	<ol style="list-style-type: none"> <li>1. Мэдээллийн технологийн үндэсний парк</li> </ol>	

**В. Гол өгөгдлийн бүрдлийн ерөнхий тодорхойлолт**

Өгөгдлийн бүрдэл	Эзэмшигч байгууллага	Байгаа эсэх	Цахим эсэх	Файлын формат	Онлайн эсэх	Төлбөртэй эсэх	Бүрэн эсэх	Тэмдэглэл	Лицензтэй эсэх	5 од
Төсөв болон төсвийн төсөл	Сангийн яам	Тийм	Тийм	PDF, HTML	Тийм	Үгүй	Бүрэн, саланги	Төсвийн төслийг их хурлын цахим хуудас болон төсвийн хуваарь болон төсвийн хуваарьт орсон өөрчлөлтийн өгөгдлийг сангийн яамны цахим хуудаснаас харах боломжтой байна	Байхгүй	★
Төсвийн тайлан болон санхүүгийн төлөвлөгөө	Сангийн яам	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Бүрэн бус, саланги	Сангийн яамны цахим хуудас болон шилэн дансны цахим хуудас хоёроос өгөгдлүүдийг цуглуулж авах боломжтой байна. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа учир өгөгдөл бүрэн бус.	Байхгүй	★
Тусламж, зардал	Сангийн яам	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Саланги	Шилэн дансны цахим хуудаснаас төсвийн зардал болон тусламжийн өгөгдлийг шүүж цуглуулж авах боломжтой. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа учир өгөгдөл бүрэн бус.	Байхгүй	★
Төслийн хөрөнгө оруулалт	Сангийн яам	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Саланги	Шилэн дансны цахим хуудасны төсөл хөтөлбөр цэсээс төсөл хөтөлбөр бүрээр өгөгдлийг цуглуулж авах боломжтой	Байхгүй	★
Үндэсний статистик	Монгол улсын үндэсний статистикийн хороо	Тийм	Тийм	Олон төрөл, API	Тийм	Үгүй	Бүрэн	Статистикийн өгөгдлийн бүрдлүүд олон төрөл байдаг тул өгөгдлийн бүрдэл шинэчлэгдэх хугацаа олон янз бүр байна.	CC BY 4.0	★★★
Хүн амын тооллого	Монгол улсын үндэсний статистикийн хороо	Тийм	Тийм	Олон төрөл, API	Тийм	Үгүй	Бүрэн	Боловсруулаагүй хувилбараар цогц байдлаар татаж авах боломжтой.	Байхгүй	★★★
Парламент болон түүгээр	УИХ тамгын газар	Тийм	Тийм	PDF, DOCX	Тийм	Үгүй	Бүрэн		Байхгүй	★★

хэлэлцэгдэж буй хуулийн төсөл											
Батлагдан мөрдөгдөж байгаа хууль, журам	Хууль зүй, дотоод хэргийн яам	Тийм	Тийм	HTML, PDF, DOCX	Тийм	Үгүй	Бүрэн		Байхгүй	★★	
Худалдан авах ажиллагааны болон тендер	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	Тийм	Тийм	Олон төрөл, API	Тийм	Үгүй	Бүрэн	Нээлттэй өгөгдлийн систем нь нийтэд танилцуулагдвал их өгөгдөл байгаа	Байхгүй	★★★	
Олон нийтийн байгууллагын бүртгэл	Хууль зүй, дотоод хэргийн яам	Тийм	Үгүй					Ямар нэг байдлаар олон нийтийн байгууллагын бүртгэл цахимд байршаагүй байна			
Төрийн байгууллага болон төрийн үйлчилгээ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Тийм	Тийм	HTML, PDF	Тийм	Үгүй	Саланги	Төрийн үйлчилгээний өгөгдлийг тухайн байгууллага бүрийн цахим хуудаснаас олж авах боломжтой.	Байхгүй	★	
Зам, тээвэр	Зам, тээврийн хөгжлийн яам	Тийм	Тийм	HTML, PDF	Тийм	Үгүй	Саланги	Төмөр зам, Далайн тээвэр, Авто зам барих, ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийн үзлэг, ачаа тээвэрлэлт, дугаар үйлдвэрлэлт тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн жагсаалтууд pdf ээр харах боломжтой. Нийслэлийн нийтийн тээврийн чиглэл, зогсоолын өгөгдөл смарт картын цахим хуудас дээрээс зургаар харах боломжтой байна.	Байхгүй	★	
Гэмт хэргийн бүртгэл	Хууль зүй, дотоод хэргийн яам	Тийм	Тийм	Олон төрөл	Тийм	Тийм	Бүрэн	service.police.gov.mn цахим хуудас дээр гэмт хэргийн бүртгэл болон гэмт хэргийн байрлалыг харуулах систем байгаа боловч өгөгдөл нь байхгүй байна. Гэвч ҮСХ-д өгөгдөл байна. Байрлалын хувьд сум хамгийн бага нэгж болж байна.	Байхгүй	★★★	
Мэргэжлийн хяналт	Мэргэжлийн хяналтын	Тийм	Тийм	PDF	Тийм	Үгүй	Саланги	Ерөнхий байцаагчийн шийдвэр, даргын шийдвэр, дагаж мөрдөх дүрэм журам	Тодорхой гүй	★	

	ерөнхий газар								inspection.gov.mn сайт дээр нийтлэгдсэн байдаг. 2016 оноос 27 чиглэлээр хяналтын маягтын дагуу khyanalt.gov.mn Шилэн хяналт системээр тайлан бүртгэж байгаа.		
Хуулийн этгээдийн бүртгэл	Оюуны өмч, улсын бүртгэлийн газар	Тийм	Тийм	Өгөгдлийн сан	Үгүй	Тодорхой бус	Бүрэн		Оюуны өмч улсын бүртгэлийн газраас нэг ч нээлттэй өгөгдөл гаргаагүй байна. Харин статистик мэдээллээ зураг хэлбэрээр тавьсан байна.	Байхгүй	★★★
Кадастр	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	Тийм	Тийм	Өгөгдлийн сан	Үгүй	Тодорхой бус	Бүрэн		egazar.gov.mn цахим хуудас дээрээс газрын зурган өгөгдөл харах боломжтой байна	Тодорхойгүй	★★★
Орон зайн суурь өгөгдөл	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	Тийм	Тийм	Өгөгдлийн сан, HTML	Тийм	Үгүй	Бүрэн		egazar.gov.mn цахим хуудас дээрээс газрын зурган өгөгдөл харах боломжтой байна	Байхгүй	★★★
Хаяг бүртгэл	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	Тийм	Тийм	HTML	Үгүй	Тийм	Бүрэн		Хаяг бүртгэл одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиараа Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын эзэмшлийнх байдаг. Улсын хэмжээнд шинэ хаяг төлөвлөгдсөн, систем ажиллаж эхлээгүй байгаа болно.	Байхгүй	★
Сонирхол татах газар	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тийм	Тийм	Өгөгдлийн сан	Үгүй	Тодорхой бус	Бүрэн		Гео-мэдээллийн сангийн цахим хуудас дээрээс байгаль орчны мэдээллийн сангийн програм хангамжаар газрын зураг дээрээс аялал зуучлалтай холбоотой бүх газрын байрлал үзэх боломжтой	Тодорхойгүй	★★★
Цаг агаар	Цаг уур, орчны шинжилгээний газар	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Бүрэн бус		5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ tsag-agaar.mn цахим хуудас дээрээс үнэгүй авах боломжтой. Харин бусад хугацааны цаг агаарын мэдээг үнэтэйгээр авч болно.	Байхгүй	★
Барилга, зөвшөөрөл, бүсчлэл	Барилга, хот байгуулалтын яам	Тийм	Тийм	XML	Тийм	Архивын өгөгдөл төлбөр	Бүрэн		Барилга, зөвшөөрөл, бүсчлэл нь орон нутгийн удирдлагын харьяа байгууллагад байдаг. Улаанбаатар хотын барилга, зөвшөөрөл, бүсчлэлийн өгөгдөл нь Улаанбаатар хотын ерөнхий	Үгүй	★★★



						тэй		төлөвлөгөөний газрын цахим хуудас дээр мэдээ хэмээх цэсэд байрласан байна.		
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл	Оюуны өмч, улсын бүртгэлийн газар	Тийм	Тийм	HTML, PDF	Тийм	Үгүй	Саланги	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар байгаа боловч нээлттэй нийтэлсэн өгөгдөл байхгүй байна	Байхгүй	★
Оюуны өмчийн бүртгэл	Оюуны өмч, улсын бүртгэлийн газар	Тийм	Үгүй	Өгөгдлийн сан	Үгүй	Тодорхой бус	Бүрэн	Хуучин оюуны өмчийн газрын цахим хуудас дээр бүрэн өгөгдөл байна	Тодорхойгүй	★★★★
Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	Санхүүгийн зохицуулах хороо	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Бүрэн	Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудаснаас өгөгдөл авах боломжтой мөн статистикийн хорооны цахим хуудаснаас өгөгдөл авах боломж давхар байна.	Байхгүй	★
Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг	Авлигатай тэмцэх газар	Тийм	Тийм	PDF	Тийм	Үгүй	Саланги	Авлигатай тэмцэх жил болгон өгөгдлийн нээлттэй нийтэлдэг.	Байхгүй	★
Боловсролын байгууллагын бүртгэл	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Тийм	Тийм	PDF	Тийм	Үгүй	Саланги	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны цахим хуудасны боловсрол цэсэд өгөгдөл нь харьцангуй сайн чанартай html хүснэгт хэлбэртэй боловч хаяг мэдээлэл байхгүй зөвхөн холбоо барих хүн утасны дугаар байна.	Байхгүй	★
Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл	Эрүүл мэндийн яам	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Саланги	Эрүүл мэндийн яамны цахим хуудасны байгууллагууд цэсээс улсын эрүүл мэндийн байгууллагуудын холбоосыг авах боломжтой байна. Харин хувийн эмнэлэг болон эмийн мэдээллийг авах холбоос байгаа хэдий ч ажиллахгүй байна. Мөн сайдын тушаал дээрээс шүүлт хийн эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл бүртгэлийг олох боломжтой байна.	Байхгүй	★
Эмийн	Эрүүл мэндийн	Тийм	Тийм	HTML,	Тийм	Үгүй	Саланги	Эмийн сангийн мэдээлэл эрүүл мэндийн	Байхгүй	★

сангийн бүртгэл	яам			PDF			хэдий ч зарим өгөгдөл дутуу	даатгалын газар байгаа гэсэн боловч эрүүл мэндийн даатгалын цахим хуудас байхгүй байна. Гэхдээ зөвхөн эрүүл мэндийн даатгалын газрын бүртгэлтэй эмийн сангуудын мэдээлэл байна. Бүх эмийн сангийн мэдээллийг авахад эрүүл мэндийн сайдын тушаалаас олох боломжтой		
Монгол улсын стандарт	Стандартчилал , хэмжил зүйл газар	Тийм	Тийм	PDF	Үгүй	Үгүй	Саланги	Зарим стандарт үнэгүй байдаг боловч ихэнх стандартыг тогтсон тарифын дагуу зарж борлуулдаг		★
Ашиг малтмал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Тийм	Тийм	PDF	Тийм	Зарим нь төлбөр гүй	Бүрэн	Монгол улсын геологийн каталогийн системээс Монгол улсын геологийн хураангуй мэдээллийг харах боломжтой байна	Ашиглах нөхцөл байгаа	★
Усны нөөц	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тийм	Тийм	HTML	Тийм	Үгүй	Бүрэн	Байгаль орчны яамны харьяа Байгаль орчны мэдээллийн төвийн ус, рашааны мэдээллийн сангаас монгол орны бүх төрлийн усны өгөгдлүүдийг газрын зургаар харах боломжтой байна.	Үгүй	★
Тусгай зөвшөөрөл	Бүх яам, ХХЗХ	Тийм	Тийм	HTML, PDF	Тийм	Үгүй	Саланги	Засгийн газрын яамдын чиг үүрэгт хамаарах тусгай зөвшөөрөл олгосон мэдээлэл яам тус бүрийн цахим хуудас дээрээс харах боломжтой.	Байхгүй	★

### *Г. Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөлт*

#### **ТАНИЛЦУУЛГА**

Үйл ажиллагааны төлөвлөлтийг Монгол Улсын нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээний (НӨББҮ) үр дүн, нээлттэй өгөгдлийг амжилттай эхлүүлж хэрэгжүүлсэн бусад орны туршлагад үндэслэн гүйцэтгэсэн. Төлөвлөгөөнд багтсан үйл ажиллагаа бүрийг шинээр байгуулах Нээлттэй өгөгдлийн ажлын хэсэг (НӨАХ) голчлон хариуцаж гүйцэтгэхээр тусгасан болно.

#### ***Нээлттэй өгөгдөл хэрэгсэл болох нь***

Төрд байгаа өгөгдлийг хэн нэгэнд ямар нэг хязгаарлалтгүй дахин ашиглуулахаар нийтлэх нь нээлттэй өгөгдлийн үндсэн зорилго байгаагүй. Нээлттэй өгөгдөл бол төрийн болон бусад байгууллага хоорондын хамтын (шинэ) ажиллагааг илүү өргөн сэдэв, асуудлын хүрээнд үүсгэж хөгжүүлэх хэрэгсэл юм. Энэ хэрэгслээр төрийн байгууллагын үр ашиг, үр дүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, ил тод байдал болон нийгэм эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж болно.

#### ***Нээлттэй өгөгдөл дээрээс доошоо, дундаас гадагшаа, доороос дээшээ чиглэлтэй эхэлдэг***

Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн үйл ажиллагааг дээд, дунд, доод гурван түвшинд хоорондын нягт уялдаа холбоо, нарийн зохион байгуулалтайгаар зэрэгцүүлэн хэрэгжүүлдэг. Нээлттэй өгөгдлийн институтийн үүсгэн байгуулагч Тим Бернерс-Ли “Нээлттэй өгөгдөл дээрээс доошоо, дундаас гадагшаа, доороос дээшээ чиглэлээр хөгждөг” гэж дүгнэсэн байдаг.

- Дээд түвшинд хууль эрх зүй, засгийн газрын бодлогын орчин хамаарна. Энэ түвшин нээлттэй өгөгдлийг үүсгэх боломжийг бий болгоно.
- Дунд түвшинд өгөгдлийг хадгалж эзэмшдэг салбарын яамд, агентлагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийг илэрхийлсэн өгөгдөл, төрийн байгууллага хооронд нээлттэй өгөгдлийн хэрэглээ зэрэг багтана. Энэ түвшин засгийн газрын ил тод, үр ашигтай, үр дүнтэй байдлыг хангадаг.

- Доод түвшинд нээлттэй өгөгдлийг хэрэглэх гаднын эрэлт хэрэгцээ хамаарах бөгөөд нээлттэй өгөгдлийг ашиглах, нийтлэх эхний түүчээ төслүүд нь бизнесийн, нийгмийн болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны эрэлхийлэл болдог. Энэ нь нээлттэй өгөгдлийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл юм.

Эдгээр гурван түвшин бие биедээ нөлөөлж нэгнийгээ дэмжиж сайжруулдаг. Түүчээ төслүүд бол төрийн өгөгдөл эзэмшигчид болон гаднын оролцогч талууд хамтран нээлттэй өгөгдлийг хэрхэн амжилттай хөгжүүлж болдгийг харуулна. Мөн ийм төслүүд төрийн байгууллагын дотор эсвэл төрийн зохицуулалтын түвшинд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг харуулах доороос-дээш чиглэсэн гол санаачилга болно. Тэр дундаа төрийн зохицуулалтын түвшинд хийх өөрчлөлт нь доороос-дээш чиглэсэн бусад шинэ санаачилгын эхлэл юм. Салбарын яамд, агентлагууд үүнтэй холбоотой тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлснээр одоо мөрдөгдөж буй бодлого, эрх зүйн орчны практик ач холбогдлыг харуулдаг байна. Мөн гаднын оролцогч талууд нээлттэй өгөгдлийг ашиглан нийгэмд үзүүлэх нөлөөллийг бий болгоход ажлын гол талбар болох юм. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэлт бол “хийх үедээ суралцаад явах” үйл явц бөгөөд үүнд төлөвлөөгүй, урьдчилан хараагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой боловч үйл ажиллагаа нь бусад түвшинд хамааралтай эсвэл хоорондоо холбоотой байхыг ямагт шаардана.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


### ***Нээлттэй өгөгдлийн ажлын хэсэг бол гол холбох гүүр***

НӨББҮ-ий явцад өгөгдөл хадгалдаг хэд хэдэн яам, агентлаг нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд цаашид хамтран ажиллах сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байсан. Мөн ЗГХЭГ-ыг нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд голлох, хүчтэй манлайлагч болж ажиллахыг санал болгосон. ЗГХЭГ нь нээлттэй өгөгдлийг манлайлах, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, амлалтыг олон нийтэд болон засгийн газрын түвшинд илэрхийлж идэвхтэй ажиллах шаардлагатай гэж үзсэн. Иймд НӨАХ-ийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргаар удирдуулан, бодлого тодорхойлогч гол яамд, агентлагуудыг оролцуулж бусад төрийн бус байгууллага болон иргэний нийгэм, бизнесийн байгууллага зэрэг хэрэглэгч талын оролцоог хангасан байдлаар

бүрдүүлснээр нээлттэй өгөгдлийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх боломжтой. Ажлын хэсгийн ийм бүтэц нь Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийг эхлүүлэхэд тохирох хувилбар болно.

Энэ үйл ажиллагааны төлөвлөгөөг НӨАХ голлон хэрэгжүүлэх бөгөөд төлөвлөгөөнд Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн эхэн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг багтаасан.

Мөн төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийн үр ашиг, ач холбогдлыг харуулах түүчээ төслүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан. Энэ төсөлд ашиглах өгөгдөл нь богино хугацаанд хялбар нийтэлж болох, төрийн байгууллагын болон нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхүйц байх нь чухал юм. Гол нь нээлттэй өгөгдлөөр ямар үр дүнд хүрч болохыг олон нийтэд таниулсан сайн жишээ болох ёстой бөгөөд эдгээр төсөл нь оролцогчдод юу хийх хэрэгтэйг суралцах боломж олгодог. Үүний зэрэгцээ түүчээ төслөөр нийтэлсэн өгөгдөл нийгмийн оролцоог уриалсан алхам болно. Ийм үйл ажиллагаа иргэний нийгэм, бизнесийн болон төрийн байгууллага хоорондын цаашдын хамтын ажиллагааны итгэлцлийг бэхжүүлнэ.



**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалтыг хүснэгтээр харуулав. Үйл ажиллагаа бүрийн хувьд хэрэгжүүлэх хугацаа, хамаарах түвшин болон хариуцагч талыг НӨАХ-ээс гадна бусад талуудын оролцоог хангасан байхаар тусгасан.

Дээд, дунд болон доод түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааг НӨББҮ-ний найман хэмжүүрийн тохирох бүлэгт оруулж боловсруулсан. Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь жагсаалтад тусгасан үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй. НӨАХ болон бусад талын санал шүүмжид үндэслэн хэрэгжүүлэлтийн явцад өөрчлөх боломжтой боловч түвшин хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог алдагдуулахгүй байх шаардлагатай.

Товчоор хэлбэл, өнөөгийн нөхцөл байдалд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгцээтэй, хэрэгжих боломжтой үйл ажиллагаануудыг жагсаалтад тусгав.

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАРЬЯАЛАХ ХЭМЖҮҮР	ХАРИУЦАГЧ	ХУГАЦАА	ТАЙЛБАР
A1.	Нээлттэй өгөгдлийн ажлын хэсгийг өргөтгөж, эрхлэх асуудлыг тодорхойлох	1. Удирдлагын манлайлал	ЗГХЭГ	M1	Нээлттэй өгөгдлийн ажлын хэсгийг (НӨАХ) ЗГХЭГ-ын дарга/дэд даргаар ахлуулж хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог хангасан хэлбэрээр өргөтгөн зохион байгуулах; НӨАХ-ийн хариуцах асуудлыг нарийвчлан тодорхойлж үйл ажиллагааг идэвхжүүлэх;
A2.	Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	1. Удирдлагын манлайлал	ЗГХЭГ, НӨАХ	M1-2	НӨББҮ-ий үр дүн, дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэж Үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулах; Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний удаах төлөвлөгөөнд нээлттэй өгөгдлийн алхмуудыг холбогдох үйл ажиллагаанд уялдуулан тусгаж оруулах;
A3.	Нээлттэй өгөгдөл, өгөгдлийг дахин	2. Бодлого, эрх зүйн орчин	ЗГХЭГ, НӨАХ,	M12-24	Мэдээллийн ил тод байдал, төрийн өгөгдөл,

	<p>ашиглах тухай ойлголт, өгөгдлийг нийтлэх, ашиглах зохицуулалтыг өнөөгийн хууль эрх зүйн орчинд оруулах</p>		ХХМТГ		<p>мэдээллийг нийтлэх, олон нийтэд түгээхтэй холбоотой одоо мөрдөгдөж хуулийн зохицуулалтыг тодорхойлсны үр дүнд төрийн өгөгдлийг дахин ашиглах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;</p> <p>Өгөгдөл хамгаалах хуулийг боловсруулж батлуулах;</p>
A4.	<p>Нээлттэй өгөгдөлд ашиглах ерөнхий нээлттэй лицензийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нутагшуулах</p>	2. Бодлого, эрх зүйн орчин	НӨАХ болон Хууль зүйн яам, ХХМТГ	M1-3	<p>Бүтээлч хамтын өмч (Creative Commons) лицензүүдийг төрийн нээлттэй өгөгдлийн үндсэн лицензээр сонгох;</p> <p>CC0 (нийтийн өмч), CC-BY (нэр дурдах), CC-BY-SA (нэр дурдах болон цааш нь ижил нөхцөлөөр түгээх) лицензийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нутагшуулах;</p>
A5.	<p>Нээлттэй өгөгдлийн манлайлагчдыг дэмжих</p>	4. Төрийн өгөгдлийн менежмент, өгөгдлийн бэлэн байдал	НӨАХ	M3-24	<p>Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааг дэмжиж сурталчлах, удирдан ажиллах, хэрэгжүүлэх манлайлагчдыг төрийн байгууллагууд болон нээлттэй өгөгдлийн хэрэглэгчид дундаас тодорхойлох, тал бүрийн дэмжлэг үзүүлж нягт хамтарч ажиллах;</p>
A6.	<p>Нээлттэй өгөгдлийн түүчээ төслийг тодорхойлж хэрэгжүүлэх</p>	5. Нээлттэй өгөгдлийн эрэлт	НӨАХ, холбогдох төрийн байгууллага, бусад оролцогч	M6-24	<p>Нээлттэй өгөгдлийн үр өгөөжийг нийгэм, төрийн байгууллагуудад сурталчлан таниулахад чиглэсэн түүчээ төслүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх;</p> <p>Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай өндөр нөлөө үзүүлж чадах</p>

					<p>өгөгдлийн бүрдлийг тодорхойлж нийтлэх;</p> <p>Түүчээ төслийг иргэний нийгэм, бизнесийн байгууллагын оролцоотой хамтарч хэрэгжүүлэх;</p> <p>Түүчээ төслийг амжилттай хэрэгжүүлэхэд орон зайн суурь өгөгдөл, НӨАТУС-ын өгөгдөл, Зээлийн мэдээллийн сан, тендерийн өгөгдөл зэргийг ашиглах боломжийг эхний ээлжид судлах;</p>
A7.	Өгөгдлийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтныг тодорхойлох	3. Байгууллагын бүтэц, төрийн хариуцлага, чадамж	ЗГХЭГ, НӨАХ, Төрийн албаны зөвлөл, ХХМТГ	M6-12	<p>Төрийн байгууллагуудын түвшинд нэгдсэн өгөгдлийн менежментийн асуудлыг зохицуулах, чиглүүлэх удирдах албан тушаалтны үүргийг тодорхойлох;</p> <p>Төрийн байгууллага бүрийн хувьд одоо байгаа бүтцийн хүрээнд тохирох чиг үүргийн удирдах албан тушаалтны ажил үүргийн хуваарьт оруулах;</p> <p>Бүх шатны менежерүүдийн үр дүнгийн гэрээнд нээлттэй өгөгдөл нийтлэх асуудлыг тусгах;</p>
A8.	Төрийн нээлттэй өгөгдлийн үндэсний порталыг үүсгэх	4. Төрийн өгөгдлийн менежмент, өгөгдлийн бэлэн байдал	НӨАХ, ҮДТ	M3-24	<p>Төрийн байгууллагуудын нээлттэй өгөгдлийг нийтлэх нэгдсэн порталыг нээлттэй эхийн SKAN системээр хөгжүүлж нэвтрүүлэх, тасралтгүй үйл ажиллагаагаар хангах;</p> <p>Нээлттэй өгөгдлийн хуулбар хувийг хадгалж түгээхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх сонирхолтой, дата төвийн бизнес эрхлэгч байгууллагын дэмжлэг туслалцааг авах;</p>
A9.	Төрөөс иргэд	5. Нээлттэй	НӨАХ,	M3-24	Төрийн өгөгдлийн



	олон нийт, хувийн хэвшлүүдээс хүсдэг өгөгдөл, мэдээллийн бүртгэлийг үүсгэж нийтлэх	өгөгдлийн эрэлт	Өгөгдөл нийтлэх байгууллага		эрэлтийг тодорхойлох үүднээс төрийн байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн хүсэлтийн бүртгэлийг байгууллагууд тус бүр үүсгэж эдгээрийг нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд тогтмол нийтэлдэг байх;
A10.	Төрийн байгууллагуудад нээлттэй өгөгдлийн талаар сургалт, танилцуулга хийх	3. Байгууллагын бүтэц, төрийн хариуцлага, чадамж	ЗГХЭГ, НӨАХ	M12	Төрийн бүх шатны байгууллагын удирдах албан тушаалтан болон мэргэжилтнүүдийн хувьд нээлттэй өгөгдлийн танилцуулгыг улирал бүр нэг удаа хийх; Гарын авлага бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулж зохион байгуулах;
A11.	Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилтийг олж тодорхойлох	7. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилт	ЗГХЭГ, НӨАХ	M6-12	Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэх; Түүчээ төслийн санхүүжилтийг олон талын эх үүсвэрээс олж тодорхойлох; Өгөгдлийг боловсруулж нийтлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг өгөгдлийг нь нийтлээд ашиглах сонирхолтой хувийн хэвшилтэй хамтран ажиллах замаар шийдвэрлэх;
A12.	Чанартай нээлттэй өгөгдлийг нийтлэх	4. Төрийн өгөгдлийн менежмент, өгөгдлийн бэлэн байдал	Өгөгдөл нийтлэх байгууллага, НӨАХ	M19	Нийгэмд хэрэгцээтэй, өндөр үр өгөөжтэй төрийн өгөгдлийг тодорхойлж нээлттэй өгөгдлийн порталд нийтлэх (өгөгдлийн портал төрийн өгөгдлийг хайж олох нэг цонх байх бөгөөд өгөгдөл тухайн байгууллага дээр байрлах тохиолдолд заах холбоосыг оруулдаг); Төрийн болон албаны нууцын тухай хуульд

					<p>нийцүүлэн нээлттэй байж болох өгөгдлийн бүрдлийг тодорхойлж байгууллага бүр нээлттэй өгөгдлийн жагсаалтыг гаргах;</p> <p>Орон зайн суурь өгөгдөл, НӨАТУС-ын өгөгдөл, Зээлийн мэдээллийн сан, тендерийн өгөгдөл, нийгмийн даатгалын өгөгдөл зэрэг нийгэмд чухал нөлөө үзүүлэх өгөгдлийг эхний ээлжид нийтлэх;</p>
A13.	Нээлттэй өгөгдлийг олон нийтэд таниулан сурталчлах	6. Иргэдийн оролцоо, нээлттэй өгөгдлийн боломж	НӨАХ, Түүчээ төсөл хэрэгжүүлэгчид	M6-12	Нээлттэй өгөгдлийн үндсэн ойлголт болон давуу тал, түүний хэрэглээ, түүчээ төслийн үр дүн, сайн жишээ, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталыг олон нийтийн мэдээллийн сувгаар нийгэмд таниулан сурталчлах;
A14.	Нээлттэй өгөгдлийн экосистемийг дэмжсэн үйл ажиллагаа зохион байгуулах, оролцогч талуудтай харилцах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	6. Иргэдийн оролцоо, нээлттэй өгөгдлийн боломж	НӨАХ, бусад оролцогч	M3-6	Нээлттэй өгөгдлийн экосистемийг бий болгох болон дэмжсэн үйл ажиллагаа болох хакатон, апп уралдаан, инкубаторын програм, төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг өгөгдөл хэрэглэгчдэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж сургалт зохион байгуулах;
A15.	Нээлттэй өгөгдлийн Үйл ажиллагааны дараагийн төлөвлөгөөг боловсруулж батлах	1. Удирдлагын манлайлал	НӨАХ	M1-2	Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний шатны хэрэгжилтийг үнэлж 2 дахь шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах

Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө

ҮЙЛ АЖИЛЛАГАА	ЭХЛЭХ САР	ИХДЭЭ ҮРГЭЛЖЛЭХ	БАГАДАА ҮРГЭЛЖЛЭХ	САРУУД																							
				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24
A1. Нээлттэй өгөгдлийн ажлын хэсгийг өргөтгөж, эрхлэх асуудлыг тодорхойлох	1	1	1	1																							
A2. Нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	1	2	1	1	1																						
A3. Нээлттэй өгөгдөл, өгөгдлийг дахин ашиглах тухай ойлголт, өгөгдлийг нийтлэх, ашиглах зохицуулалтыг өнөөгийн хууль эрх зүйн орчинд оруулах	1	24	12	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A4. Нээлттэй өгөгдөлд ашиглах ерөнхий нээлттэй лицензийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нутагшуулах	2	3	1		1	1	1																				
A5. Нээлттэй өгөгдлийн манлайлагчдыг дэмжих	3	24	3			1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A6. Нээлттэй өгөгдлийн түүчээ төслийг тодорхойлж хэрэгжүүлэх	2	24	6		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A7. Өгөгдлийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтныг тодорхойлох	3	12	6			1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A8. Төрийн нээлттэй өгөгдлийн үндэсний порталыг үүсгэх	3	24	3			1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A9. Төрөөс иргэд олон нийт, хувийн хэвшлүүдээс хүсдэг өгөгдөл, мэдээллийн бүртгэлийг үүсгэж нийтлэх	5	24	3				1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A10. Төрийн байгууллагуудад нээлттэй өгөгдлийн талаар сургалт, танилцуулга хийх	6	12	12				1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A11. Нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн санхүүжилтийг олж тодорхойлох	2	12	6		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A12. Чанартай нээлттэй өгөгдлийг нийтлэх	6	24	24				1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A13. Нээлттэй өгөгдлийг олон нийтэд таниулан сурталчлах	3	12	6			1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A14. Нээлттэй өгөгдлийн экосистемийг дэмжсэн үйл ажиллагаа зохион байгуулах	9	6	3							1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
A15. Нээлттэй өгөгдлийн Үйл ажиллагааны дараагийн төлөвлөгөөг боловсруулж батлах	22	2	1																						1	1	1

Төгсгөлийн сар: 24

Ихдээ үргэлжлэх хугацаа

Багадаа үргэлжлэх хугацаа